



**МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН
ДҮГНЭЛТ**



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/96

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Төсвийн байнгын хороо, Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Н.Цэвэлмаа), олон нийтэд мэдээлэхийг Тамгын дарга, тэргүүлэх аудитор (Б.Бундхорол) нарт тус тус даалгасугай.

3.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал болон холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Санхүүгийн аудитын газар (Н.Цэвэлмаа), Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд), Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа), Тусгай чиг үүргийн аудитын газар (Д.Баярсайхан), Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар (Ч.Цэвэгдорж)-т тус тус үүрэг болгосугай.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2027 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Н.Учрал), Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд (Ж.Энхбаяр), Сангийн сайд (З.Мэндсайхан) нарт тус тус зөвлөсүгэй.

5.Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (З.Цэдэнжав)-д даалгасугай.



С.МАГНАЙСҮРЭН

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН БОДЛОГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ	7
Төсвийн ерөнхийлөн захирагч нарын зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг.	8
БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ УРТ, ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛТАЙ ЗАРЧМЫН ХУВЬД НИЙЦЭЖ БАЙНА.	9
БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГАТАЙ НИЙЦЭЖ БАЙНА.	11
БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ТӨЛӨХ ТАТВАРЫГ БУУРУУЛАХ, ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛСЭН, ТӨРИЙН ӨМЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НОГДОЛ АШГИЙГ ДАЙЧИЛСАН ЗОРИМОГ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН Ч ТҮҮХИЙ ЭДИЙН МӨЧЛӨГ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН СОРИЛТООС ШАЛТГААЛАН ТӨСВИЙН ОРЛОГО ТАСРАХ, ЭХ ҮҮСВЭРИЙН ДУТАГДЛЫГ ДАРАА ЖИЛИЙН ТАТВАРААС УРЬДЧИЛАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ЭРСДЭЛ ҮҮСГЭЖ БОЛЗОШГҮЙГ АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ	13
3.1 Уул уурхайн салбарын голлох нэр төрлийн бүтээгдэхүүний эрэлт болон зах зээлийн дундаж үнэ өсөлттэй байгаа үеийн үзүүлэлтэд үндэслэн 2027 онд биет хэмжээний зорилтод хүрээгүйгээс орлого тасарч, холбогдох төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдаж болзошгүй.....	13
3.2 Татварын орлогыг өмнөх оноос 29.3 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн нь татвар болон нийгмийн даатгалын хуулийн шинэчлэлийн нөлөөгөөр төсөвт төвлөрүүлэх орлого бүрдэхгүй байх эрсдэлтэй байна.	14
3.3 Татварын бус орлогод “Оюу толгой” ХХК-аас 3,000.0 тэрбум төгрөг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас 2,506.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.	16
БҮЛЭГ 4. ХУУЛЬЧЛАГДСАН УРСГАЛ ЗАРДЛЫН ТЭЛЭЛТ БУСАД ЗАРДЛЫН БҮТЦЭД НӨЛӨӨЛЖ, ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН АЧ ХОЛБОГДЛЫГ БУУРУУЛЖ, ХӨГЖИЛД ЧИГЛЭСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН ОРОН ЗАЙГ ХЯЗГААРЛАЖ, ТҮҮХИЙ ЭДИЙН МӨЧЛӨГ ДАГАСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙСЭЭР БАЙНА.	20
4.1 Дунд хугацааны төсвийн хүрээний мэдээгдэл, төсвийн төсөөллөөр баталсан нийт зарлага ба цэвэр зээлийн дээд хэмжээ хуульчлагдсан зардлын тэлэлтийн нөлөөллөөр жил бүр тэлж, төлөвлөлтөийн ач холбогдлыг бууруулж, төсвийн тогтвортой байдлыг алдагдуулж байна.	20
4.2 Хуульчлагдсан зардлын нөлөөгөөр Монгол Улсын 2027 оны төсвийн зарлага өмнөх оноос 32.2 хувиар	байна.
нэмэгдсэн	21
4.3 Монгол Улсын 2027 оны улсын төсвийн урсгал зардал нийт зарлага ба цэвэр зээлийн 77.5 хувийг эзэлж, өмнөх оноос 33.2 хувиар нэмэгдсэн байна.	22
4.4 Төсвийн зардлыг хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй бүрэн уялдуулан төлөвлөөгүй, үр дүнгийн үзүүлэлтүүдийг үндэслэлтэй, хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоогүй байгаа нь хэрэгжилтийн үр дүнг бодитой хэмжих, тайлагнах, үнэлэх боломж буурч, төсвийн хөрөнгийн үр ашиггүй	байна.
зарцуулалт	үүсч
болзошгүй	байна.
.....	23
БҮЛЭГ 5. ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЛИЙГ ТУСГАЙ ШААРДЛАГА БОЛОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЛИЙГ ХАНГАХААР БОЛОВСРУУЛСАН БОЛОВЧ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ СУЛРАХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.	24
5.1 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон шинэчилж өргөн барьсан төсвийн хүрээний мэдээгдэлд заасан шалгуурыг хангасан боловч өмнөх оны батлагдсан төсвөөс 1,256.0 тэрбум төгрөгөөр төсвийн алдагдлыг нэмж төсөвлөсөн байна.	24
5.2 Монгол Улсын 2027 оны төсвийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө дунд хугацааны төсвийн хүрээний мэдээгдэлд өөрчлөлт оруулах саналыг өргөн мэдүүлсэн байна. Төсвийн хүрээний мэдээгдэлд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдахгүй тохиолдолд төсөв төсвийн хүрээний мэдээгдэлд нийцэхгүй байх эрсдэлтэй байна	24
БҮЛЭГ 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЛДЭГДЛИЙГ НЭРЛЭСЭН ДҮНГЭЭР 56,628.7 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЭХЭЭР ТООЦСОН НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГАД НИЙЦСЭН БОЛОВЧ ГАДААД ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ ӨНДӨР БАЙГАА НЬ ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ӨР, ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЛИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙНА.	25
6.1 Төсвийн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 56,628.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ийн 49.6 хувийг эзэлж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдээгдэл болон Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт заасан зорилтот түвшнийг хангаж байна.	25

БҮЛЭГ 7. ТЭРГҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДЛЫН ЭРЭМБЭ, ӨРТГИЙН ТООЦОО СУДАЛГААГ ИХ ӨГӨГДӨЛД СУУРИЛАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ОНОВЧТОЙ, ҮР АШИГ БАГАТАЙ БАЙХАД АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	30
7.2 Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөр тухайн жилд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 2027 оны төсвийн төсөлд бүрэн тусгасан байна.	31
7.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2027 оноос эхлэн хэрэгжүүлэх 318 төсөл, арга хэмжээний 18.2 хувь нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй нь богино хугацааны бодлого зорилт, түүний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.	31
7.4 Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг үнэлсэн ч аргачлалын дагуу бус, бодитой, оновчтой байдал хангалтгүй байгаа нь үр ашиг, хэрэгцээ шаардлага багатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрсдэлийг дагуулж байна	33
7.5 Тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний тэргүүлэх хэрэгцээ шаардлага, өртгийг суурь өгөгдөл, судалгаанд тулгуурлан төлөвлөхгүй байгаа нь төсвийн зарцуулалтын үр ашигт сөргөөр нөлөөлж байна	36
7.6 ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төсөл, арга хэмжээний өртгийг бодитой, төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, хяналт хангалтгүй байгаа нь эрсдэл дагуулж байгааг анхаарах шаардлага байна.	38
7.7 Тухайн жилийн санхүүжилтийг дутуу төлөвлөж байгаа нь хэрэгжилт удаашрах, дараагийн жилүүдийн хөрөнгө оруулалтын орон зайг хязгаарлах эрсдэлийг дагуулж байна.....	39
ДҮГНЭЛТ	41
ЗӨВЛӨМЖ	43

ХҮСНЭГТ

Хүснэгт 1: Төсөвт туссан саналын товчоо	8
Хүснэгт 2. Монгол улсын 2027 оны нэгдсэн төсвийн нийт орлого	13
Хүснэгт 3. Уул, уурхайн гол нэр төрлийн барааны үндсэн үзүүлэлтүүд	14
Хүснэгт 4. Татварын орлогыг төрөл, өсөлт, бууралт, нийт орлогод эзлэх хувь	14
Хүснэгт 5. Татварын зардал буюу хөнгөлөлт, чөлөөлөлтийн судалгаа	15
Хүснэгт 6. Гаалийн ерөнхий газрын татварын орлого бүрдүүлэлт	15
Хүснэгт 7. Татварын бус орлого /бүрэлдэхүүнээр/ задаргаа	16
Хүснэгт 8. Чингис хаан үндэсний баялгийн сан нэгдэл ХХК-ийн харьяа уул уурхайн компаниудаас төвлөрүүлэх ногдол ашиг	17
Хүснэгт 9. Төрд учруулсан хохирлын мэдээлэл (2024, 2025, 2026/08 сар)	17
Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага	18
Хүснэгт 11. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага	18
Хүснэгт 12. ОН-ийн төсөвт төвлөрүүлэх агаарын бохирдлын төлбөрийн орлого	19
Хүснэгт 13. Төсвийн хүрээний мэдэгдэлд орсон өөрчлөлт /Монгол Улсын 2027 нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дээд хязгаар/	20
Хүснэгт 14 Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл /Бүрэлдэхүүнээр/	20
Хүснэгт 15. Монгол Улсын 2027 нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл ангилал,	21
Хүснэгт 16. Төрийн албан хаагчийн тоо хүн амын тооны харьцуулалт	21
Хүснэгт 17. Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	22
Хүснэгт 18. Нэгдсэн төсвийн 2027 оны тэнцвэржүүлсэн тэнцэл	24
Хүснэгт 19. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд	25
Хүснэгт 20. Засгийн газрын өрийн бүтэц, хэрэгсэл	25
Хүснэгт 21. Засгийн газрын өрийн үйлчилгээ, нийт төлөвлөгөө	27
Хүснэгт 22. Засгийн газрын өрийн 2027 оны төлөвлөгөө	27
Хүснэгт 23. Засгийн газрын 2026 2027 оны гадаад зээл ийн төлөвлөгөө	28
Хүснэгт 24. Улсын төсвийн 2027 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөл	30
Хүснэгт 25. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн төлөвлөсөн эх үүсвэр	30
Хүснэгт 26. УТХО-ын төсөл, арга хэмжээнүүд болон УХЖТ-ний уялдаа	32
Хүснэгт 27. УХЖТ-ний хөтөлбөрийн үр дүнтэй уялдаагүй 58 төсөл, арга хэмжээ	32
Хүснэгт 28. Зураг төсөв алдаатай 7 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл	35

ДҮРСЛЭЛ

Дүрслэл 1. Тогтвортой байдлын хязгаар /хувь/	26
Дүрслэл 2. Гадаад зээлийн 2027 оны ашиглалтын төлөвлөгөө	28
Дүрслэл 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих	30
Дүрслэл 4. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ, ТЕЗ-аар	34
Дүрслэл 5. Улсын төсвийн тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний санхүүжилт	36
Дүрслэл 6. Шинээр хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээ	36
Дүрслэл 7. ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд хийх ажлын өртгийг харилцан адилгүй төлөвлөсөн байдал	38
Дүрслэл 8. 2023-2026 оны Улсын төсвийн зарлагын бүтцийн өөрчлөлт /нийт зардалд эзлэх хувь/	39
Дүрслэл 9. Аудитаар хамгийн олон давтагдсан зөвлөмж	40

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 болон Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэлээ. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2027 оны төсвийн төслийг улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлж, төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэн боловсруулсан эсэхэд дүгнэлт гаргахад аудитын зорилго чиглэсэн. Үүнд: а) Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэх; б) төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх; в) төсвийн орлогыг бодит тооцоо, судалгаанд үндэслэн, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд тулгуурлан үндэслэлтэй төлөвлөсөн эсэх; г) төсвийн урсгал зарлагыг үр ашигтай, хэмнэлттэй байхаар, хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнтэй уялдуулан төлөвлөсөн эсэх; д) улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан, төлөвлөлтийн шаардлага хангасан эсэх; е) төсвийн төслийн тэнцвэржүүлсэн тэнцэл (ашиг, алдагдал)-ийг үндэслэлтэй тооцож, алдагдлыг нөхөх эх үүсвэрийг тусгай шаардлага болон хууль тогтоомжид нийцүүлж боловсруулсан эсэх.
Аудитын зорилго	Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав. Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсөв /улсын төсөв, орон нутгийн төсөв, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн төсөл, 2026, 2025/, төсвийн гүйцэтгэл /урьдчилсан/, төсвийн ерөнхийлөн захирагчид болон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүдийг хамруулан гүйцэтгэв. Мөн аудитад Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд цуглуулсан төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт зэргийг ашиглав.
Аудитын хамарсан хүрээ	

**Талуудын хүлээх
үүрэг, хариуцлага**

Засгийн газар улсын төсөв, орон нутгийн төсөв /суурь орлого, зарлага/, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсвийн төслийг танилцуулгын хамт Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.5-д заасны дагуу жил бүрийн 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.2, 23.1.3-т заасны дагуу Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд дүгнэлт гарган Улсын Их Хуралд жил бүрийн 09 дүгээр сарын 15-нд хүргүүлэх үүрэг хүлээнэ.

Аудитын багийн бүрэлдэхүүн:

- Санхүүгийн аудитын газар: Газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн хэрэгжүүлж, ахлах аудитор, аудиторууд гүйцэтгэсэн;
- Гүйцэтгэлийн аудитын газар: Газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер М.Наранжаргал хэрэгжүүлж, ахлах аудитор, аудиторууд гүйцэтгэсэн;
- Нийцлийн аудитын газар: Газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Н.Анхбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор, аудиторууд гүйцэтгэсэн.

**Аудитын
бүрэлдэхүүн, хугацаа**

МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН БОДЛОГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

1. Олон улсын геополитик, эдийн засгийн төлөв байдал харилцан адилгүй, гадаад зах зээл дэх газрын тос, уул уурхайн түүхий эдийн эрэлт, нийлүүлэлт зэргээс шалтгаалан худалдааны түнш орнуудын бодлогын сорилтуудтай тулгарч болзошгүй байна. Олон улсын валютын сангийн төсөөллөөр дэлхийн эдийн засаг 2026 онд 3.0 хувь, 2027 онд 3.4 хувь, БНХАУ-ын эдийн засаг 2026 онд 4.6 хувь, 2027 онд 4.1 хувиар өсөх төлөвтэй гэж дүгнэсэн боловч дотоодын зах зээлийн эргэлт, өрхийн хэрэглээ хумигдсанаар эдийн засгийн идэвхжилийг сааруулах төлөвтэй байна.

2. Монгол Улсын эдийн засгийн өсөлт эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн мөчлөг дагасан, гадаад худалдаанаас хамааралтай хэвээр байна. Эдийн засаг 2026 оны 7 дугаар сарын байдлаар 7.7 хувь буюу 52,486.0¹ тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар өссөн бол 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 5.7 хувь, 2027 онд 5.8 хувийн өсөлт үзүүлнэ гэж тооцжээ.

3. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд төсөв болон мөнгөний бодлогын тохируулга хийх замаар харилцан уялдааг сайжруулах шаардлагатай байна. Инфляц 2026 оны 7 дугаар сарын байдлаар 13.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.9 нэгж хувиар өссөн бөгөөд оны төгсгөлд Төв банкны зорилтот түвшнээс өндөр гарах хүлээлттэй байна. Харин 2027 онд инфляцын түвшинг 8.0 хувь байхаар төлөвлөсөн боловч шатахуун, мах, хүнсний ногооны нийлүүлэлтийн доголдол бий болох эрсдэл хадгалагдсаар байна.

4. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2027 онд 31,955.0 сая ам.доллар, экспорт 19,680.0 сая ам.доллар, импорт 13,850.0 сая ам.доллар, худалдааны нийт тэнцэл 6,475.0² сая ам.доллар байхаар төлөвлөсөн байна. Харин нүүрсний экспортыг 7,500.0 сая ам.доллар, зэсийн баяжмалыг 7,550.0 сая ам.доллар, алтыг 1,360.0 сая ам.доллар, төмрийн хүдрийг 605.0 сая ам.доллар, газрын тосыг 255.0 сая ам.долларын арилжаа хийхээр тусгасан байна.

5. Төсвийн орлого бүрдүүлэгч уул уурхайн эрдэс баялгийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний дундаж үнийг 68.0 ам.доллар/тн, зэсийг 12,700 ам.доллар/тн, алтыг 4,200.0 ам.доллар/унц, газрын тосыг 70.0 ам.доллар/бар, төмрийн хүдрийг 64.0 ам.доллар/тн байхаар, экспортын биет хэмжээг нүүрс 110.0 сая.тн, зэсийн баяжмал 2,065.0 мян.тн, алт 10.4 тн, газрын тос 3,650.0 мян.бар, төмрийн хүдэр 9,470.0 мян.тн байхаар тус тус төлөвлөсөн байна.

6. Улсын Их Хурлаар 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 34,780.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 30.4 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 36,493.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 28.4 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,713.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувийн алдагдалтай байхаар анх баталсан байна.

7. Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 41,280.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.8 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 43,586.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.8 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,306.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн алдагдалтай байхаар тусгажээ.

8. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны 07 дугаар сарын гүйцэтгэлээр нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 17,300.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 19,507.2 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 2,206.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

¹ ЭЗХЯ-ны Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл

² ЭЗХЯ-ны Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл

9. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т заасны дагуу 2027 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөллийг тооцохдоо нэрлэсэн ДНБ-ийг 115,300.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

10. Монгол Улсын 2027 оны төсвийн бодлогод “Чөлөөлье” үндэсний санаачлагын хүрээнд “Эдийн засгийн чөлөөлөлт”, “Ногоон чөлөөлөлт”, “Авилгын эсрэг чөлөөлөлт”, “Эрх зүйн чөлөөлөлт” гэсэн бодлогын дөрвөн чиглэл, 27 зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

11. Төсөвт баримтлах бодлогыг “Иргэдийн бодит орлого, нийгмийн баталгааг хамгаалах, төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулахад чиглүүлнэ. Үүний зэрэгцээ боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, эрчим хүч, зам, логиستيкийн хүртээмжийг сайжруулж, төрийн бүтээмж, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэн, ипотекийн зээлийн хүртээмжийг өргөжүүлнэ. Төсвийн зарцуулалт бүрийн хэрэгцээ, бэлэн байдал, үр өгөөжөөр эрэмбэлж, улсын төсвийг хувийн хэвшил, орон нутаг, гадаад зээл, тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтыг татах хөшүүрэг болгон ашиглахын зэрэгцээ төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хадгална” гэж тодорхойлсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг.

12. Төсвийн тухай хуулийн 281 дугаар зүйлд төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж, салбар бүрээр хэлэлцүүлэг зохион байгуулахаар заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нар танхимын хэлэлцүүлгийг 2026 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс 07-ны өдрийн хооронд зохион байгуулсан байна.

13. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэгт 40852 оролцогч хамрагдсанаас 1288 иргэн танхимаар, 39624 иргэн бусад хэлбэрээр оролцсон байна. Нийт 26247 санал ирүүлснээс 264 санал танхимын хэлэлцүүлгээр, 25983 санал цахим болон бусад хэлбэрээр санал өгсөн байна.

14. Иргэдийн гаргасан 26247 саналаас ТЕЗ нар өөрсдөө эрэмбэлэн төсвийн төсөлд тусгах боломжтой гэж үзсэн нийт 8,245.0 тэрбум төгрөгийн 113 санал, үүнээс 5,953.8 тэрбум төгрөгийг урсгал зардалд, 2,291.2 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус тусгасан байна.

Хүснэгт 1: Төсөвт туссан саналын товчоо

/тэрбум төгрөгөөр/

№	ТЕЗ	Саналын тоо	Төсөв
1	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	3	66.6
2	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	3	50.3
3	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	2	4,398.2
4	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД, ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	4	-
5	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	3	164.9
6	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	3	-
7	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	13	-
8	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	1	1,421.8
9	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	1	-
10	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	3	20.7
11	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	5	-
12	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	5	-
13	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	12	-
14	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	10	189.3
15	БОЛОВСРОЛЫН САЙД	10	-
16	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	7	-
17	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	1	2.1
18	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА	2	14.4
19	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	12	-
20	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	3	-
21	ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	4	37.5
22	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	5	1,164.6
23	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	1	35.5
	НИЙТ	113	8,245.0

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

15. Олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан төсөвт тусгагдаагүй арга хэмжээнүүд нь 2027 оны төсвийн хязгаарт багтаагүй, төсөл, арга хэмжээний мэдээлэл тодорхойгүй, бодлогын шинэчлэл шаардлагатай саналууд дийлэнх хувийг эзэлсэн байна.

16. Цаашид олон нийтийн хэлэлцүүлгийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, танхимаар зохион байгуулж байгаа хэлэлцүүлэгт салбарын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн төрийн бус байгууллага, иргэдийг түлхүү оролцуулах, хэлэлцүүлгээс гарсан санал, үр дүнг иргэд, олон нийтэд эргэн танилцуулдаг байх шаардлагатай байна.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ УРТ, ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛТАЙ ЗАРЧМЫН ХУВЬД НИЙЦЭЖ БАЙНА.

1.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.3 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3, 9.2.6 дахь заалтад тус тус зааснаар улсын төсвийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хөгжлийн зорилтот хөтөлбөр, таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн батлахаар заасан.

1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”, 9 дүгээр зүйлийн 9.5.1-д “улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “төсөв нь хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” зарчмыг тус тус тогтоосон.

1.3. Монгол Улсын 2027 оны төсвийн төслийг татвар, нийгмийн даатгал, тэтгэврийн тогтолцооны шинэчлэл, хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлого, боловсролын хүртээмж, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах чиглэлд төлөвлөсөн нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүний хөгжил, нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, хүнсний хангамж, эрчим хүч, дэд бүтцийн тогтвортой байдлыг хангах зорилтуудтай нийцэж байна. Тухайлбал:

- Эрчим хүчний 1,172.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын багц, авто замын 1,722.4 тэрбум төгрөгийн санхүүжилт, хөдөө аж ахуйн 205.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, боомт, логистикийг нэмэгдүүлэх 465.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, ажлын байр дэмжих 2,421.6 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн нь “Алсын хараа-2050”-ын хүний хөгжил, эдийн засгийн төрөлжилт, амьдралын чанар ба бүсчилсэн хөгжлийн зорилго, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын эрчим хүч, боомт, аж үйлдвэржилт, хот-хөдөөгийн сэргэлтийн чиглэлтэй нийцсэн байна;
- боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд 356 төсөлд 1,400.5 тэрбум төгрөг санхүүжүүлж, сургууль, цэцэрлэгийн хүртээмж, дотуур байр, 100 сургуулийн эрчим хүчний шинэчлэл, хүүхэд бүрд компьютер арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь хүний хөгжил, боловсролын чанар ба тэгш хүртээмж, ногоон хөгжил, бүсчилсэн хөгжлийн зорилтыг дэмжиж байна;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад 165 төсөлд 414.7 тэрбум төгрөг санхүүжүүлж, бүсийн нэгдсэн эмнэлэг, эрхтэн шилжүүлэн суулгах болон зүрх судасны төв, аймаг ба анхан шатны тусламжийг дэмжихээр төлөвлөсөн нь эрүүл мэндийн чанар, хүртээмж, бүсийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилттой нийцсэн байна.

1.4. Харин зарим арга хэмжээний үр дүнгийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг хөгжлийн бодлогын холбогдох үр дүнтэй бүрэн уялдуулаагүйгээс тэдгээр арга хэмжээ нь урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилтын хэрэгжилтийг дэмжих эсэхийг үнэлэх боломж хязгаарлагдмал байна. Тухайлбал:

- Тэтгэврийн багц хууль болон тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэлд 2,672.8 тэрбум төгрөг, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны хамгаалалд нийт 9.5 их наяд төгрөгийн арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь нийгмийн хамгаалал, орлогын тэгш бус байдлыг бууруулах зорилготой нийцсэн боловч нэмэгдлийн хэмжээ нь зорилтот бүлгийн бодит хэрэгцээ, ядуурал ба бодит орлогын хэмжих үзүүлэлтэд хэрхэн нөлөөлөх тооцоо танилцуулгад бүрэн бус байна;

- сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, цахилгаан тээврийн хэрэгслийн татварын чөлөөлөлт нь ногоон хөгжил ба эрчим хүчний шилжилттэй нийцсэн боловч татварын орлогын алдагдал, эрчим хүчний нэмэлт хүчин чадал болон хүлэмжийн хийн бууралтын тооцоо байхгүй байна;
- жижиг, дунд аж ахуйн нэгжийн татварын ачааллыг бууруулах, мянга орчим бизнес эрхлэгчид зээл олгох арга хэмжээ нь хувийн хэвшил, дундаж давхарга, ажлын байрны бодлоготой нийцэж байгаа ч зээлийн сонгон шалгаруулалт, нэмэгдэх ажлын байрны тоо, бүтээмжийн зорилтот үзүүлэлт тодорхой бус байна;
- батлан хамгаалах, хил хамгаалах, гамшигийн удирдлага, зарлан мэдээллийн тогтолцоонд 359.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөсөн нь үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх зорилттой нийцсэн. Харин бэлэн байдлын хэмжих түвшин, хамрах нутаг дэвсгэрийн эрсдэлийн эрэмбэ танилцуулгад тодорхой тусгаагдаагүй байна;
- төрийн албан хаагчдын цалин нэмэгдүүлэхэд 2,574.4 тэрбум төгрөгийн нэмэгдэх зардал төлөвлөсөн нь хөдөлмөрийн үнэлэмж, төрийн албаны тогтвортой байдалтай холбоотой боловч бүтээмж, гүйцэтгэл, төрийн бүтцийн оновчлолын шалгууртай шууд холбосон нотолгоо танилцуулгад тусгаагүй байна;
- шүүхийн барилга ба лабораторид 77.8 тэрбум төгрөг төлөвлөсөн нь шүүхийн хараат бус байдал, хүний эрх, үйлчилгээний хүртээмжийн ерөнхий зорилт дэмжихэд чиглэсэн боловч барилгын хөрөнгө оруулалт нь хэрэг хянан шийдвэрлэх хугацаа, хүртээмж, шинжилгээний чанар зэрэг хэрхэн нөлөөлөх тооцоо тодорхой бус байна.

Төсвийн төсөл нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байна.

1.5. Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, дэд бүтэц, бүсчилсэн хөгжил, байгаль орчин, цахим шилжилт, батлан хамгаалах болон хүний аюулгүй байдлыг хангах чиглэлүүд нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцэж байна. Тухайлбал:

- Боомт, логистикийн хүчин чадал болон авто замын сүлжээг нэмэгдүүлэх төсөл нь ҮАБҮБ-ын 3.1.2.6³, 3.2.1.4⁴ 3.2.4.2⁵-д заасан хил хамгаалалт, хилийн боомтын нэвтрүүлэх чадвар, экспортын төрөлжилтийг дэмжих;
- эрчим хүчний салбарын 1.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын багц болон ногоон эрчим хүчний татварын дэмжлэг нь 3.2.2.4⁶, 3.2.4.211-т заасан эрчим хүчний найдвартай байдал, дотоодын эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- хөдөө аж ахуйн салбарын 205.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, үйлдвэрлэл, услалтын системийн төслүүд нь 3.4.2.3⁷-т заасан хүнсний хангамж, импорт орлох үйлдвэрлэлийг дэмжих;
- “Эрүүл Монгол хүүхэд” эрт илрүүлэг, хөнгөлөлттэй эмийн 79.0 тэрбум төгрөгийн дэмжлэг, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, сургуулийн хоол, “Гэрт ойрхон сургууль”, “Ногоон, ухаалаг сургууль”, гамшигийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоо, шүүхийн чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ нь 3.4.1⁸, 3.4.3⁹, 3.3.1.7¹⁰-д заасан хүний эрүүл мэнд, амьдрах орчны аюулгүй байдал, гамшигийг сөрөн тэсвэрлэх чадавх, дотоод аюулгүй байдлыг бэхжүүлэхэд тус тус чиглэжээ.

1.6. Зарим арга хэмжээний бодлогын хэрэгжүүлэх арга хэлбэр, санхүүжилтийн бүтэц нь тогтвортой төсөв, санхүүгийн салбарын бодлогод сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэж болзошгүй байна. Тухайлбал:

- Суурь тэтгэвэрт 1,216.4 тэрбум төгрөг зарцуулах, төрийн албан хаагчдын цалин нэмэгдүүлэх зэрэг байнгын шинжтэй урсгал зардлыг тэтгэврийн сангийн актуар тооцоо, төрийн албаны бүтээмж, орон тооны шинэчлэлттэй хангалттай уялдуулаагүй тохиолдолд төсвийн суурь

³ Хил дээр боомт нээх, хаах, боомтын ажиллагааны горимд өөрчлөлт оруулах асуудлыг төрийн эрх барих дээд байгууллага шийдвэрлэнэ

⁴ Дэд бүтцийн салбарын хөгжлийг үндэсний аюулгүй байдлын шаардлагад нийцүүлж, хөрөнгө оруулалтад эдийн засгийн үр ашгийг шалгуур болгоно. Төмөр замын сүлжээг байгуулахдаа Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэнэ

⁵ Эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах зорилгоор өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана

⁶ Гадаадын хөрөнгө оруулалтыг өрсөлдөх чадвар, санхүү, менежментийн үр өгөөжийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, урт хугацааны хөгжлийн үндсийг тавих чухал хөшүүрэг, арга хэрэгсэл болгоно

⁷ Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшигийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана.

⁸ Эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

⁹ Амьдрах орчны аюулгүй байдал

¹⁰ Иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх үзэл санааг дээдэлсэн хараат бус, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлнэ. Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх эдийн засгийн баталгаа бий болгоно

зардлыг өсгөж, цаашид зардлыг бууруулах боломжийг хязгаарлан төсвийн тогтвортой байдалд дарамт учруулж болзошгүй байна;

- дундаж давхаргыг дэмжих бизнесийн зээлийн хөтөлбөрийн 55.0 тэрбум төгрөгийн свопын зардал болон ипотекийн зээлийн 198.0 тэрбум төгрөгийн төсвийн дэмжлэг нь зээлдэгчийн сонголт, зээлийн чанар, төсвийн нийт өртөг, болзошгүй өр төлбөрийг тодорхой тооцоогүй нөхцөлд санхүүгийн эрсдэлийг төсөвт шилжүүлэх, зээлийн болон орон сууцны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлж үнийн өсөлтийг өдөөх эрсдэлтэй;
- боомт, эрчим хүч, авто зам зэрэг стратегийн төслүүдийн санхүүжилтэд гадаад зээл, тусламжийн эзлэх хувь нэмэгдэх нь дэд бүтцийн аюулгүй байдлыг сайжруулахын зэрэгцээ санхүүжүүлэгч улс, валют, технологиос хэт хамаарах, өрийн үйлчилгээний дарамт нэмэгдэх эрсдэлийг дагуулж болзошгүй байна.

1.7. ҮАБҮБ-ын 3.2.2.2-т гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрүүлэхгүй, стратегийн салбар дахь хөрөнгө оруулалтын улсын бүтцийг тэнцвэртэй байлгахаар заасан. 2027 оны Төсвийн тухай хуулийн төсөлд тусгасан гадаад зээл, тусламжийн 94 төсөлд нийт 1,773.5 тэрбум төгрөг төлөвлөснөөс нэг улсын эзлэх хувь гуравны нэгийн босгоос хэтрээгүй байна. Хамгийн өндөр буюу 16.5 хувийг БНХАУ-ын хөрөнгө оруулалт эзэлж байна.

1.8. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулиар хэрэгжүүлэх төслүүдийг авч үзвэл нийт гадаад зээлийн ашиглалт 4,245.3 тэрбум төгрөг, үүнээс Энэтхэгийн газрын тос боловсруулах үйлдвэрийн зээл 2,290.5 тэрбум төгрөг буюу 54.0 хувийг эзэлж байна.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГАТАЙ НИЙЦЭЖ БАЙНА.

2.1 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг нэгэн зэрэг хангасан байх шаардлагыг тогтоосон.

2.2 Төсвийн төсөлд зэс, нүүрсний үнийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тэнцвэржүүлсэн журмаар тооцож, 2027 оны зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 10,249.9 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 125.4 ам.доллар байхаар тооцсон нь нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох шаардлагад нийцсэн байна.

2.3 Нэгдсэн төсвийн урсгал зардлыг 33,583.2 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь 2027 оны нэрлэсэн ДНБ-ий ойролцоогоор 29.1 хувь бөгөөд хуульд заасан 30 хувийн хязгаараас 0.9 нэгж хувиар доогуур байна. Энэ нь урсгал зарлагын тусгай шаардлагыг тоон үзүүлэлтийн хувьд хангаж байгаа боловч төсвийн бодлогын орон зай хязгаарлагдмал байгааг харуулж байна.

2.4 Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээг 2027 онд 49.6 хувь байхаар төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан 60.0 хувийн дээд хязгаараас 10.4 нэгж хувиар доогуур байна. Төсвийн алдагдал болох 2,306.0 тэрбум төгрөгийг гадаадын хөнгөлөлттэй зээл болон дотоодын үнэт цаасны эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

2.5 Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагыг тоон шалгуурын хувьд хангасан байна. Гэхдээ урсгал зарлагын хэмжээ хуульд заасан дээд хязгаарт харьцангуй ойртсон, төсвийн нийт зарлага өндөр өсөлттэй, төсвийн орлогын өсөлтөд уул уурхай болон төрийн өмчит компаниудын ногдол ашгийн орлого гол байр суурь эзэлж байгаа нь төсвийн гүйцэтгэлийн эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

2.6 Улсын Их Хурлын 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр баталсан 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 34,780.0 тэрбум төгрөг, нийт зарлагын дээд хэмжээг 36,493.4 тэрбум төгрөг байхаар баталсан.

2.7 Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2027 оны төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлогыг 41,280.0 тэрбум төгрөг, нийт зарлагыг 43,586.0 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2,306.0 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн байгаа нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа төсвийн хүрээний мэдэгдэлтэй харьцуулахад тэнцвэржүүлсэн орлого 6,500.0 тэрбум төгрөгөөр, нийт зарлага 7,092.6 тэрбум төгрөгөөр, алдагдлыг 592.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэ нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан нийт зарлагын дээд хязгаар болон тэнцвэржүүлсэн тэнцлийн үзүүлэлтэд

нийцээгүй байгааг хангах үүднээс төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх саналыг өргөн мэдүүлсэн байна.

2.8 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд төсвийн төсөл боловсруулах, батлахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх зарчим тогтоосон. Гэвч төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх саналыг УИХ-д өргөн мэдүүлсэн нь дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн хязгаар тогтоох үндсэн зорилгыг сулруулж, төсвийн сахилга бат, дунд хугацааны төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.

2.9 Төсөв нь улсын болон орон нутгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангах, хариуцлагатай байх гэсэн таван үндсэн зарчмыг баримтлахаар хуульчилсан байдаг.

2.10 Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл нь Төсвийн тухай хуульд заасан зарчмуудыг хангаж байгаа боловч төсвийн тогтвортой байдал болон санхүү, төсвийн зохистой удирдлагын зарчмын хэрэгжилтэд эрсдэл үүсгэж болзошгүй байна. Хүчин төгөлдөр төсвийн хүрээний мэдэгдлийн хязгаарыг давсан зарлагын төлөвлөлт, орлогын огцом өсөлт, урсгал зарлага хуулийн дээд хязгаарт ойртсон байгааг анхаарах шаардлагатай байна.

Төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн дагалдах хууль тогтоомжийн төслүүд төсвийн бодлоготой уялдсан боловч төсөвт үзүүлэх нөлөөг бүрэн тодорхойлох шаардлагатай байна.

2.11 Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэхээр заасан.

2.12 Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан 7 хуулийн төслийг хамт өргөн мэдүүлсэн байна.

2.13 Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд оруулах нэмэлтээр цахилгаан автомашин, механизм, нарны зайн хавтан, цэнэглэх төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх зохицуулалтыг 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хэрэгжүүлэхээр тусгасан байгаа нь төсвийн орлогод үзүүлэх нөлөө зөвхөн 2027 онд бус 2028-2029 онуудад үргэлжлэхээр байна.

2.14 Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслөөр орон сууц, гэр дулаалахад зориулсан материал худалдан авсан зардалд татварын хөнгөлөлт үзүүлэх зохицуулалтыг Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс мөрдөхөөр заасан боловч үйлчлэл дуусах хугацааг тогтоогоогүй байна.

2.15 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөр цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх ногоон өртөө байгуулах зардлыг татварын хөнгөлөлтөд хамруулах, мөн төрийн болон орон нутгийн өмчит болон өмч давамгайлсан хуулийн этгээдийг нийгмийн хариуцлагын татварын хөнгөлөлтөөс хасах байнгын зохицуулалт тусгасан байна.

2.16 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр шашны байгууллагын өмчилж байгаа тодорхой үл хөдлөх хөрөнгийг хадгалж, хамгаалж буй хугацаанд нь татвараас 100 хувь хөнгөлөхөөр тусгасан бөгөөд мөн хугацааг хязгаарлаагүй байна.

2.17 Төсвийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөөр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 50 хувийг иргэдийн саналд үндэслэн, үлдэх 50 хувийг хуулиар тодорхойлсон чиг үүрэгт зарцуулах болон төсвийн зарлагын хэмнэлт, нэмэлт орлогын журмыг батлах эрхийг Засгийн газарт шилжүүлэх зэрэг байнгын шинжтэй өөрчлөлт тусгасан байна.

2.18 Нийгмийн болон суурь дэд бүтцийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай хуулийн төсөл нь 2027 оны төсвийн жилд Оюу толгой төслөөс төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогын тодорхой хэсгийг улсын төсөвт төвлөрүүлж, нийгмийн болон суурь дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхээр тусгасан байгаа нь хугацааны хувьд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийн шаардлагад нийцэж байна.

2.19 Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь тухайн жилийн нэгдсэн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлахад шууд үйлчлэх ба төсөвт тусгай шаардлагууд нь нэгэн зэрэг хангагдсан байхыг шаарддаг. Гэвч тус хуулийн төслийн 5 дугаар зүйлд "...ногдох ногдол

ашгийн орлогоор санхүүжүүлэх зардал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад хамаарахгүй” гэж тусгасан.

БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ТӨЛӨХ ТАТВАРЫГ БУУРУУЛАХ, ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛСЭН, ТӨРИЙН ӨМЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НОГДОЛ АШГИЙГ ДАЙЧИЛСАН ЗОРИМОГ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН Ч ТҮҮХИЙ ЭДИЙН МӨЧЛӨГ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН СОРИЛТООС ШАЛТГААЛАН ТӨСВИЙН ОРЛОГО ТАСРАХ, ЭХ ҮҮСВЭРИЙН ДУТАГДЛЫГ ДАРАА ЖИЛИЙН ТАТВАРААС УРЬДЧИЛАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ЭРСДЭЛ ҮҮСГЭЖ БОЛЗОШГҮЙГ АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.1 Уул уурхайн салбарын голлох нэр төрлийн бүтээгдэхүүний эрэлт болон зах зээлийн дундаж үнэ өсөлттэй байгаа үеийн үзүүлэлтэд үндэслэн 2027 онд биет хэмжээний зорилтод хүрээгүйгээс орлого тасарч, холбогдох төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдаж болзошгүй.

3.1.1 Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн орлогод дэвшүүлсэн татварын бодлогоор татвар болон Нийгмийн даатгалын шимтгэлийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн засаглал, үйл ажиллагааг сайжруулах, орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- Иргэдийн татварын ачааллыг бууруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил хөдөлмөр эрхэлж буй оюутан, суралцагчдыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, гарааны бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 3 хүртэлх ажилтныг 36 сараар чөлөөлөх, давхар ажил эрхэлж буй иргэний хувьд өөрийн сонголтоор аль нэг ажлаас олсон орлогод нийгмийн даатгалын шимтгэл төлөх нөхцөлийг бүрдүүлэх;
- иргэдийн анх удаа өмчилсөн орон сууцаа худалдан борлуулсны орлогод ногдох 2.0 хувийн албан татварыг чөлөөлөх, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг 90.0 хувиар хөнгөлөх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг 400.0 сая төгрөг болгон нэмэгдүүлж, татвар төлөх хугацааг 2 хүртэл сараар хойшлуулах;
- ногоон шилжилтийг дэмжих зорилгоор цахилгаан тээврийн хэрэгсэл, цэнэглэх төхөөрөмж, нарны зайн хавтан, үйлдвэрлэснээс хойш 3 хүртэлх жилийн насжилттай цахилгаан автомашин, механизмыг гаалийн албан татвараас чөлөөлөх, цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх ногоон өртөө байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагад татварын хөнгөлөлт эдлүүлэх.

3.1.2 Монгол Улсын 2027 оны нийт орлого ба тусламжийн дүнг 2026 оны батлагдсан төсвөөс 9,571.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 45,744.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь дотоодын нийт бүтээгдэхүүний 39.7 хувьд хүрэх төлөвтэй байна.

Хүснэгт 2. Монгол улсын 2027 оны нэгдсэн төсвийн нийт орлого

/тэрбум төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2025 гүйц	2026 бат	2027 төс	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	33,179.3	36,172.2	45,744.0	9,571.8
Үндэсний баялгийн сан	2,876.1	4,242.2	3,980.2	(262.2)
Ирээдүйн өв сан	1,710.6	2,886.5	3,277.8	391.3
Хуримтлалын сан	603.0	528.9	702.4	173.5
Тогтворжуулалтын сан	562.5	826.8	483.8	(343.0)
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	30,303.2	31,930.0	41,280.0	9,350.0

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

3.1.3 Үндэсний баялгийн сангийн 3,980.2 тэрбум төгрөгийн орлогод Ирээдүйн өв сангийн 3,277.8 тэрбум төгрөг, Хуримтлалын сангийн 702.4 тэрбум төгрөг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

3.1.4 Ирээдүйн өв сангийн орлогыг өмнөх оноос 391.3 тэрбум төгрөгөөр, Хуримтлалын сангийн орлогыг 173.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, Тогтворжуулалтын сангийн орлогыг 343.0 тэрбум төгрөгөөр бууруулж, төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 9,350.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

3.1.5 Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 9,350.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 41,280.0 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөсөн нь худалдааны эргэлт, уул уурхайн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх, төрийн өмчийн

хуулийн этгээдийн ногдол ашгийг төсөвт дайчлах арга хэмжээг төлөвлөсөнтэй холбоотой байна.

3.1.6 Нүүрс, зэсийн баяжмалын экспорт болон холбогдох татварын орлогын нөлөөгөөр 2027 онд уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 10,908.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь ДНБ-ий 9.5 орчим хувийг бүрдүүлэхээр байна.

Хүснэгт 3. Уул, уурхайн гол нэр төрлийн барааны үндсэн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Бүтээгдэхүүн нэр төрөл	Биет хэмжээ			2027	Үнэ, ам доллар/нэгж		2027	Орлого /тэрбум төгрөг/		2027
	х/н	2025	2026		2025	2026		2025	2026	
		гүйц	Бат		гүйц	Бат		гүйц	Бат	Төл
Нүүрс	сая.тн	90.0	90.0	110.0	64.1	70.0	68.0	4,373.8	4,907.1	4,591.2
Зэсийн баяжмал	сая.тн	2.3	1.9	2,065.0	9,938.6	9,700.0	12,700.0	3,697.5	2,933.5	4,082.8
Алт, тушаасан (цэвэр жингээр)	тн,\$/унц	11.3	20.0	10.4	3,429.2	2,800.0	4,200.0	579.9	519.2	992.7
Төмрийн хүдэр	сая.тн	8.8	9.2	9,470.0	72.1	70.0	64.0	457.8	317.2	323.0
Цайр*	мянт.тн	149.2	-	-	2,866.5	-	-	182.1	158.5	112.0
Жонш*	мянт.тн	1,830.0	-	-	176.6	-	-	69.4	154.3	124.0
Бусад	-	-	-	-	-	-	-	661.3	569.4	682.6
Нийт	-	-	-	-	-	-	-	10,021.8	9,559.1	10,908.3

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

3.1.7 АМНАТ-ийн орлогыг нүүрсний экспортын биет хэмжээг өмнөх оноос 10.0 хувиар нэмэгдүүлж 110.0 сая тонн, дэлхийн зах зээл дэх нийлүүлэлтийн өсөлтийг харгалзан нүүрсний үнийг тонн тутамд 2.0 ам.доллараар бууруулж, 68.0 ам.доллараар, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээг 5.9 хувиар бууруулж, 2,065.0 мянган тонн, Оюутолгойн ордоос олборлох зэсийн баяжмал болон түүнд агуулагдах цэвэр зэс, дагалдах үнэт металлын хэмжээ, үнийг тонн тутамд 12,700.0 ам.доллараар тус тус тооцож, нийт 5,460.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

3.2 Татварын орлогыг өмнөх оноос 29.3 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн нь татвар болон нийгмийн даатгалын хуулийн шинэчлэлийн нөлөөгөөр төсөвт төвлөрүүлэх орлого бүрдэхгүй байх эрсдэлтэй байна.

3.2.1 Татварын орлогод 33,005.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 24.6 хувийг НӨАТ, 24.0 хувийг нийгмийн даатгалын орлого, 23.8 хувийг ААНОАТ, 9.0 хувийг бусад татвар (төлбөр, хураамж) эзэлж байна.

Хүснэгт 4. Татварын орлогыг төрөл, өсөлт, бууралт, нийт орлогод эзлэх хувь /тэрбум төгрөгөөр/

Татварын төрөл	2026 он батлагдсан	2027 оны төсвийн төсөл	Зөрүү	Татварын орлогод эзлэх хувь
Нэмэгдсэн өртгийн албан татвар	7,408.2	8,104.2	696.0	24.6
Нийгмийн даатгалын орлого	6,707.0	7,918.0	1,211.0	24.0
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	6,384.8	7,726.7	1,341.9	23.8
Бусад татвар (төлбөр, хураамж)	2,475.5	2,965.2	489.7	9.0
Хувь хүний орлогын албан татвар	2,863.9	2,390.9	(473.0)	7.2
Гаалийн албан татвар	2,255.0	2,006.9	(248.1)	6.1
Онцгой албан татвар	1,331.5	1,357.9	26.4	4.1
Хөрөнгийн албан татвар	626.9	499.4	(127.5)	1.5
Тусгай зориулалтын орлого	33.0	35.9	2.9	0.1
Нийт дүн	30,085.8	33,005.1	2,919.3	100.0

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

3.2.2 Эдийн засгийн өсөлт 5.1 хувиар, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 115,300.0 тэрбум төгрөг, гол нэр төрлийн эрдэс баялгийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн зэргээс шалтгаалан ААНОАТ-ыг 1,341.9 тэрбум төгрөгөөр, НӨАТ-ийг 696.0 тэрбум төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэн, суурь тэтгэвэр олгох болсонтой холбоотой нийгмийн даатгалын орлогыг 1,211.0 тэрбум төгрөгөөр тус тус өсгөж төлөвлөжээ.

3.2.3 НӨАТ суутган төлөгч болох босгыг 400.0 сая төгрөг болгон нэмэгдүүлснээр дотоодын барааны НӨАТ-ын орлогыг 23443 аж ахуй нэгжийн 161.0 тэрбум төгрөгөөр бууруулж, 3,683.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

3.2.4 “Чөлөөлье” үндэсний санаачилгын хүрээнд хэрэгжих арга хэмжээ болон татварын багц хуулийн нэмэлт өөрчлөлтийн нөлөөгөөр татварын зардал буюу хөнгөлөлт, чөлөөлөлтийг 107.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 1,783.1 тэрбум төгрөгт хүргэхээр тооцжээ.

3.2.5 Татвар болон нийгмийн даатгалын хуулийн шинэчлэлийн хүрээнд нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг 0.4 тэрбум төгрөгт хүргэсэн, аж ахуйн нэгжийн 2.5 тэрбум төгрөг хүртэлх орлогод ногдох албан татварыг 90 хувиар хөнгөлнө, хувь хүний сарын орлогоос 792.0 мянган төгрөгийг татвараас чөлөөлсөн нь бага дунд орлоготой иргэн, аж ахуйн нэгжийн татварын ачааллыг бууруулсан байна.

Хүснэгт 5. Татварын зардал буюу хөнгөлөлт, чөлөөлөлтийн судалгаа /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2024	2025	2026 бат	2027 төс	ЗӨРҮҮ
Татварын орлогод эзлэх хувь	5.8	6.5	5.8	5.4	
1	2	3	4	5	6=5-4
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	1,587.2	1,758.6	1,676.0	1,783.1	107.1
ААНОАТ	946.5	1,086.6	1,014.5	1,051.6	37.1
НӨАТ	393.1	421.3	409.1	436.8	27.7
Гаалийн албан татвар	38.4	46.7	49.8	161.4	111.6
ХХОАТ	209.1	204.1	202.7	133.3	(69.4)

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

3.2.6 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эдийн засгийн үр өгөөжийг тухай бүр үнэлж, үр ашиггүй хөнгөлөлт, чөлөөлөлтийг үе шаттайгаар бууруулж, төсвийн орлогын тогтвортой байдлыг хангаж ажиллах шаардлагатай байна.

3.2.7 Гаалийн байгууллагын орлогыг өмнөх оноос 34.5 тэрбум төгрөгөөр нэмж 8,393.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөжээ. Үүнд: Евро азийн эдийн засгийн холбоотой байгуулсан түр худалдааны хэлэлцээрийн дагуу 367 нэр төрлийн бараанд 4 төрлөөр гаалийн тарифын хөнгөлөлтийг эдлүүлэхтэй холбоотой гаалийн албан татвар 500.6 тэрбум төгрөгөөр, автобензин, дизель түлшний хангамж, нийлүүлэлтийг тогтворжуулах, хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилготой гаалийн албан татварыг 54.8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцоолсон байна.

Хүснэгт 6. Гаалийн татварын орлого бүрдүүлэлт /тэрбум төгрөгөөр/

Татварын төрөл	2025	2026	2027	Зөрүү
	Гүйц	Бат	Төс	
Гаалийн ерөнхий газар	6,713.0	8,358.5	8,393.0	34.5
Импортын барааны НӨАТ	3,990.8	4,930.0	5,321.2	391.2
Импортын гаалийн албан татвар	1,849.2	2,267.0	2,017.8	(249.2)
Суудлын автомашины онцгой албан татвар	417.7	640.0	427.9	(212.1)
Бусад татвар	157.7	190.0	227.1	37.1
Импортын тамхины онцгой албан татвар	162.6	170.0	186.7	16.7
Импортын архины, дарсны онцгой албан татвар	70.2	70.0	93.8	23.8
Автобензин, дизель түлшний албан татвар	25.5	33.0	35.9	2.9
Импортын чихэр, чихэр орлуулагч агуулсан төрөл бүрийн ундаа, усны онцгой албан татвар	-	-	30.0	30.0
Импортын пивоны онцгой албан татвар	16.7	23.0	24.8	1.8
Өөрийн орлого	18.2	27.0	21.3	(5.7)
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	4.4	8.5	6.5	(2.0)

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

3.2.8 Эдийн засгийн төлөв, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд үндэслэн гаалийн албан татварын орлогыг 2,017.8 тэрбум төгрөг, импортын барааны НӨАТ-ын орлогыг 5,321.2 тэрбум төгрөг, импортын тамхины онцгой албан татвар 186.7 тэрбум төгрөг, суудлын автомашины онцгой албан татвар 427.9 тэрбум төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр төлөвлөжээ.

3.2.9 Дэлхийн банкны судалгаагаар Монгол Улс ААНОАТ болон НӨАТ-ын татвар төвлөрүүлэлтийн хувьд сайн гүйцэтгэлтэй байгаа хэдий ч орлогын түвшинтэй нь харьцуулахад ХХОАТ болон онцгой албан татварын орлогыг хангалттай төвлөрүүлж чадахгүй байна¹⁶.

3.2.10 Электрон тамхийг бусад тамхины нэгэн адил авч үзэж, онцгой албан татвар ногдуулаагүйгээс иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, зохисгүй хэрэглээ нэмэгдэж байгаа тул татвар ногдуулснаар хэрэглээг хязгаарлах, төсвийн орлого нэмэгдэх боломжийг ашиглаагүй байна.

3.3 Татварын бус орлогод “Оюу толгой” ХХК-аас 3,000.0 тэрбум төгрөг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас 2,506.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

3.3.1 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт төвлөрүүлээгүй 15.6 тэрбум төгрөг, ногдол ашгийн орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн 21.8 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, зөрчил давтан гаргахгүй байх 2026 оны 1491/А0111371 дугаартай албан шаардлага хүргүүлсэн байна.

3.3.2 Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль батлагдсанаар “Чингис хаан Үндэсний баялгийн сан нэгдэл” ХХК-аас 2027 оны төсвийн төсөлд 3,415.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг төвлөрүүлэхээр тусгасан байна.

3.3.3 Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.10 дахь хэсэгт “хэсгийг” гэсний дараа “улсын төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх” гэж өөрчлөх саналыг тусгасан хуулийн өөрчлөлтийг үндэслэн “Оюу толгой” ХХК-аас 3,000.0 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлж, нийгэм, эдийн засагт тулгамдсан эрүүл мэнд, боловсрол, эрчим хүч, автозам барих зэрэг дэд бүтцийн төсөл, арга хэмжээнд 2,000.0 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

3.3.4 Татварын бус орлогыг өмнөх оноос 4.5 дахин нэмэгдүүлж, 8,274.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөжээ. Нийтлэг татварын бус орлогоор 7,852.8 тэрбум төгрөг, тусламжийн орлогоор 408.1 тэрбум төгрөг, хөрөнгийн орлогоор 14.0 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлэхээр байна.

Хүснэгт 7. Татварын бус орлого /бүрэлдэхүүнээр/ задаргаа /тэрбум төгрөгөөр/

Орлогын төрөл	2024 гүйцэтгэл	2025 гүйцэтгэл	2026 төлөвлөгөө	2027 төлөвлөгөө
Татварын бус орлого	2,253.5	3,090.2	1,844.2	8,274.9
Нийтлэг татварын бус орлого	1,778.5	2,734.6	1,473.2	7,852.8
Хувьцааны ногдол ашиг	194.1	254.1	175.4	6,707.4
Хүү, торгуулийн орлого	409.2	596.7	323.8	205.9
Төсөвт байгууллагын өөрийн орлого	563.0	828.5	418.5	483.5
Түрээсийн орлого	8.6	9.2	4.0	7.1
Газрын тосны орлого	238.1	231.9	232.0	228.3
Навигацийн орлого	80.0	80.0	40.0	-
Бусад орлого	285.7	734.3	279.4	220.6
Хөрөнгийн орлого	6.3	9.9	6.0	14.0
Тусламжийн орлого	468.6	345.7	365.0	408.1

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

3.3.5 Хувьцааны ногдол ашгаар төвлөрүүлэх орлогыг өмнөх оноос 38.2 дахин нэмэгдүүлж 6,707.4 тэрбум төгрөгөөр төлөвлөжээ. Үүнд:

- “Оюу толгой” ХХК-аас 3,000.0 тэрбум төгрөг;
- “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн өмнөх жилүүдэд үүссэн төрд ногдох ногдол ашгийн хуримтлагдсан өглөгөөс 2,506.5 тэрбум төгрөг;
- “Чингис хаан үндэсний баялгийн сан нэгдэл” ХХК-ийн харьяа уул уурхайн компаниудаас 908.5 тэрбум төгрөг;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт бүртгэлтэй уул уурхайн бус төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 28 компаниас 129.9 тэрбум төгрөг;
- Орон нутгийн өмчит компаниудаас 162.6 тэрбум төгрөг.

¹⁶ Дэлхийн банкны 2025 оны “Тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн төлөөх төсвийн шинэчлэл” судалгааны тайлан

3.3.6 “Эрдэнэс Тавантолгой” ХК 2019 оноос хойш төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашигт 6,448.0 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байгаагаас 2,506.5 тэрбум төгрөг, “Чингис хаан үндэсний баялгийн сан нэгдэл” ХХК-ийн харьяа компаниудаас 908.5 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлэхээр тооцжээ.

Хүснэгт 8. Чингис хаан үндэсний баялгийн сан нэгдэл ХХК-ийн харьяа уул уурхайн компаниудаас төвлөрүүлэх ногдол ашиг /сая төгрөгөөр//

д/д	Хуулийн этгээдийн нэр	Төвлөрүүлэх ногдол ашиг
1	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	513,686.6
2	Эрдэнэс Тавантолгой ХК	361,303.1
3	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК	16,619.1
4	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	9,749.5
5	Эрдэнэс алт ресурс ХХК	6,498.4
6	Шивээ овоо ХК	31.4
7	Цемент шохой ТӨХК	607.9
Нийт дүн		908,495.9

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

3.3.7 Хүү, торгуулийн орлогод 2025 онд 623.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 596.7 тэрбум төгрөг, 2026 онд 323.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс эхний 7 сарын гүйцэтгэлээр 343.3 тэрбум төгрөгийг бүрдүүлжээ. Тус орлогыг 2027 онд 205.9 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 117.9 тэрбум төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

3.3.8 Төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг өмнөх оноос 15.5 хувиар нэмэгдүүлж, 483.5 тэрбум төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөснөөс улсын төсөвт 432.9 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 50.6 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлэхээр байна.

3.3.9 Төрийн аудитын байгууллагад төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх 2022-2026 оны 8.1 тэрбум төгрөгийн 182 шүүхийн шийдвэр байгаагаас 2026 онд 32 шийдвэр хэрэгжиж, 1.2 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу Төрийн албаны зөвлөлөөс 2026 оны 8 дугаар сарын байдлаар 0.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.3.10 Төрийн албаны зөвлөл хариуцаж, төрд учруулсан хохирлыг барагдуулж, нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн орлогын төлөвлөгөөг 0.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

3.3.11 Төрд учруулсан хохирлыг барагдуулах чиглэлээр мэдэгдэл хүргүүлэх, нэхэмжлэл гаргах, шүүхээр шийдвэрлүүлэх ажиллагаа 2024-2026 оны 8 дугаар сарын байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 9. Төрд учруулсан хохирлын мэдээлэл (2024, 2025, 2026/08 сар)

№	Агуулга	2024 он	2025	2026/08 сар
1	Мэдэгдэл хүргүүлсэн иргэн албан тушаалтны тоо	90	53	37
2	Хүргүүлсэн мэдэгдлийн тоо	117	59	47
3	Хүргүүлсэн мэдэгдлийн мөнгөн дүн (сая.төгрөг)	1582.2	1059.1	988.0
4	Нэхэмжлэл гаргасан албан тушаалтны тоо	57	53	34
5	Гаргасан нэхэмжлэлийн тоо	76	58	36
6	Гаргасан нэхэмжлэлийн мөнгөн дүн (сая.төгрөг)	1280.3	1299.4	626.3
7	Шүүхээс шийдвэрлэсэн мөнгөн дүн (сая.төгрөг)	688.6	491.1	771.8
8	Нөхөн төлсөн мөнгөн дүн (сая.төгрөг)	623.3	478.2	332.5

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, тайлбар

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

3.3.12 Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн төслийн саналд орлогыг 8,619.5 тэрбум төгрөг, зарлагыг 7,295.5 тэрбум төгрөг, тэнцлийг 1,324.0 тэрбум төгрөгийн ашигтай байхаар төсвийн хязгаар батлагдсан. ГБХНХЯ-аас төсвийн төслийн саналыг 10,930.2 тэрбум төгрөгөөр боловсруулж, хүргүүлснийг Сангийн яам 633.1 тэрбум төгрөгөөр бууруулан хянаж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

/тэрбум төгрөгөөр/

Төрөл	Нийгмийн даатгалын сангийн орлого				Нийгмийн даатгалын сангийн зарлага			
	2025 оны гүйцэт	2026 оны бат төсөв	2027 оны хяз	СЯ-өргөн барьсан	2025 оны гүйцэт	2026 оны бат төсөв	2027 оны хязг	СЯ-өргөн барь
Тэтгэврийн	4,239.8	5,006.7	-	6,193.4	5,341.2	6,003.4	-	7,168.1
Тэтгэмжийн	479.5	574.7	-	1,027.4	291.6	320.6	-	601.8
ҮОМШӨ-ний	353.3	426.4	-	380.6	52.1	70.8	-	86.5
Ажилгүйдлийн	159.3	192.4	-	-	163.7	190.0	-	-
Суурь тэтгэвэр	-	-	-	-	-	-	-	1,216.4
Шимтгэлийн болон бусад орлогын дүн	5,231.9	6,200.1	-	7,601.4	5,848.5	6,584.8	-	9,072.8
Улсын төсвөөс олгох	1,452.5	1,624.6	-	2,695.7	-	-	-	-
Сангийн нийт орлого	6,684.4	7,824.7	8,619.5	10,297.1	5,848.5	6,584.8	7,295.5	9,072.8

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

3.3.13 Сангийн орлогыг өмнөх оны батлагдсан төсвөөс 31.6 хувиар нэмэгдүүлж, 10,297.1 тэрбум төгрөг, зарлагыг 9,072.8 тэрбум төгрөг, тэнцлийг 1,224.3 тэрбум төгрөгөөр тооцож, төлөвлөсөн байна.

3.3.14 Нийгмийн даатгалын сангаас тэтгэврийн даатгалын сан 7,168.1 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сан 601.8 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 86.5 тэрбум төгрөг, суурь тэтгэвэрт 1,216.4 төгрөгөөр тус тус зарцуулахаар төлөвлөсөн ба суурь тэтгэврийг улсын төсвийн татаасаар санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.3.15 Сангийн зарлага өмнөх оноос 2,488.0 тэрбум төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчлэл, хүн амын ердийн өсөлт, суурь тэтгэвэр олгох зэргээс шалтгаалсан байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН

3.3.16 Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн төслийн саналд орлогыг 3,751.1 тэрбум төгрөг, зарлагыг 3,728.5 тэрбум төгрөг, тэнцлийг 22.6 тэрбум төгрөгөөр тооцож, хүргүүлснийг Сангийн яам 349.6 тэрбум төгрөгөөр бууруулан хянаж, УИХ-д өргөн барьсан байна.

Хүснэгт 11. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага

/тэрбум төгрөгөөр/

Төсвийн үзүүлэлт	2026 бат	2027 оны			
		Төсвийн хязгаар	Төсвийн төслийн санал	УИХ-д өргөн барьсан	Зөрүү
1	2	3	4	5	6=4-5
ЭМДС-ийн орлого	2,746.7	3,082.9	3,751.1	3,401.6	318.5
Урсгал зардал	2,458.8	2,685.0	3,728.5	3,082.8	397.8
Төсвийн тэнцэл	287.9	397.9	22.6	318.6	(79.2)
Эргэж төлөгдөх цэвэр зээл	(75.5)	(75.5)	(74.0)	(74.0)	1.5

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

3.3.17 Эрүүл мэндийн даатгалын сангаас Эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж үйлчилгээний санхүүжилтэд 2,817.6 тэрбум төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 248.8 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 16.4 тэрбум төгрөг, нийт 3,082.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

3.3.18 Он дамжсан олон жилийн насжилттай 77.2 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах, арга хэмжээ авч, орлого нэмэгдүүлэх ажил зохион байгуулаагүй байна.

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

3.3.19 Орон нутгийн төсвийн суурь орлогыг өмнөх оноос 5.9 хувиар нэмэгдүүлж, 6,601.0 тэрбум төгрөг, улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийг 41.3 хувиар нэмэгдүүлж, 983.1 тэрбум төгрөг, нийт 7,584.1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

3.3.20 Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор орон нутгийн төсөвт төвлөрөх хувь хүний орлогын албан татварыг 945.0 тэрбум төгрөгөөр бууруулж, 2,520.9 тэрбум төгрөгөөр төлөвлөжээ.

3.3.21 Орон нутгийн төсвийн 2027 оны суурь орлогыг 6,601.0 тэрбум төгрөг, суурь зарлагыг 3,629.1 тэрбум төгрөгөөр хянаж, улсын төсөвт 2,138.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орон нутгийн төсөвт үлдэх дүнг 1,228.6 тэрбум төгрөгөөр тооцож, тэнцэл 2,971.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн ба улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгт 395.3 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох орлогын шилжүүлгийг 587.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 7,584.1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оноос 254.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

3.3.22 Орон нутгийн нийт зарлага ба цэвэр зээл 254.0 тэрбум төгрөгөөр өсөхөд орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох орлогын шилжүүлэг 587.8 тэрбум төгрөг болж өмнөх 146.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

3.3.23 Уул уурхайн өгөөжийг орон нутагт илүү хуваарилах бодлогын хүрээнд орон нутгийн иргэдийн өгсөн саналаар дэмжигдсэн хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх, их засвар тоног төхөөрөмж, мал эрүүлжүүлэх, байгалийн нөөцийн менежмент, ногоон эрчим хүчний чиглэлээр дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох урсгал шилжүүлгийг 144.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Хүснэгт 12. ОН-ийн төсөвт төвлөрүүлэх агаарын бохирдлын төлбөрийн орлого /сая төгрөгөөр/

Агаарын бохирдлын төлбөр	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн төлбөр	Олборлосон түүхий нүүрсний төлбөр	2027 УИХ-д өргөн барьсан	Эзлэх хувь
Нийт			144,268.7	100.0
Өмнөговь	1,925.3	109,728.7	111,654.0	77.4
Дорноговь	2,530.4	8,708.9	11,239.3	7.8
Улаанбаатар	6,076.4	-	6,076.4	4.2
Ховд	248.2	5,291.8	5,540.0	3.8
Сүхбаатар	189.4	3,561.7	3,751.0	2.6
Дундговь	109.0	1,107.1	1,216.1	0.8
Дорнод	165.4	971.1	1,136.5	0.8
Увс	314.8	434.0	748.7	0.5
Сэлэнгэ	326.6	-	326.6	0.2
Дархан-Уул	323.8	-	323.8	0.2
Орхон	300.3	-	300.3	0.2
Төв	288.2	5.7	293.9	0.2
Архангай	154.4	103.4	257.9	0.2
Хөвсгөл	231.3	-	231.3	0.2
Хэнтий	213.6	-	213.6	0.1
Өвөрхангай	201.7	-	201.7	0.1
Баян-Өлгий	171.4	-	171.4	0.1
Завхан	143.9	-	143.9	0.1
Баянхонгор	142.6	1.3	143.9	0.1
Булган	129.3	-	129.3	0.1
Говь-Алтай	121.2	-	121.2	0.1
Говь сүмбэр	30.8	17.0	47.8	0

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нээгдсэн төсвийн төсөл

3.3.24 Хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад 2025 онд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар хугацаа хэтэрсэн 321.8 тэрбум төгрөгийн торгуулийн орлогыг тооцож, орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр тооцоогүй байна.

БҮЛЭГ 4. ХУУЛЬЧАЛГДСАН УРСГАЛ ЗАРДЛЫН ТЭЛЭЛТ БУСАД ЗАРДЛЫН БҮТЦЭД НӨЛӨӨЛЖ, ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН АЧ ХОЛБОГДЛЫГ БУУРУУЛЖ, ХӨГЖИЛД ЧИГЛЭСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН ОРОН ЗАЙГ ХЯЗГААРЛАЖ, ТҮҮХИЙ ЭДИЙН МӨЧЛӨГ ДАГАСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙСЭЭР БАЙНА.

4.1 Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллөөр баталсан нийт зарлага ба цэвэр зээлийн дээд хэмжээ хуульчлагдсан зардлын тэлэлтийн нөлөөллөөр жил бүр тэлж, төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж, төсвийн тогтвортой байдлыг алдагдуулж байна.

4.1.1 Өмнөх онуудад баталсан төсвийн хүрээний мэдэгдлийн нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг хуульчлагдсан зарлагын нөлөөллөөр тухай бүр өөрчилж ирсэн нь дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үр нөлөө, төсвийн сахилга батад сөргөөр нөлөөлж байна.

Хүснэгт 13. Төсвийн хүрээний мэдэгдэлд орсон өөрчлөлт /Монгол Улсын 2027 нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дээд хязгаар/

Хугацаа	ТХМ-д орсон нэмэлт өөрчлөлт	Зөрүү
2024.11.08	40,084.9	-
2024.12.12	38,263.0	(1,821.9)
2025.07.09	35,628.6	(2,634.4)
2025.11.12	34,626.0	(1,002.6)
2026.05.29	36,493.4	1,867.4
2026.09.01 УИХ-д өргөн барьсан	43,586.0	7,092.6
Өөрчлөлт		3,501.1

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

4.1.2 Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төслийг хуулиар баталсан төсвийн нийт зарлагын дээд хэмжээ, 2024 оны анхны төсөөлөлтэй харьцуулахад 3,501.1 тэрбум төгрөгөөр буюу 8.7 хувиар нэмэгдсэн нь төсвийн төлөвлөлтийн явцад зарлага тэлж, дунд хугацаанд тогтоосон төсвийн зарлагын хүрээний тогтвортой байдал алдагдаж байгааг харуулж байна.

4.1.3 Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар баталсан зарлагын дээд хязгаараас 7,092.6 тэрбум төгрөгөөр давуулж, 43,586.0 тэрбум төгрөгөөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь ДНБ-ний 37.8 хувийг эзэлж байна.

4.1.4 Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсөвт нийгмийн баталгааг хангах чиглэлээр дараах зардал нэмэгдүүлэхээр төлөвлөсөн нь батлагдсан зардлын дээд хязгаар давахад нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Төрийн албан хаагчийн үндсэн цалинг 2026 оны нэмэгдлийн нөлөө 1,686.3 тэрбум төгрөг, 2027 оны 2 дугаар улирлаас нэмэгдүүлэхээр төлөвлөсөн 888.1 тэрбум төгрөг;
- тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд 2,672.8 тэрбум төгрөг;
- хүүхдийн цогц хөгжил, аюулгүй байдлыг хангахад 320.4 тэрбум төгрөг;
- орон нутгийн хөгжлийн санд 146.9 тэрбум төгрөг;
- шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтад 385.3 тэрбум төгрөг;
- тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, хөдөө орон нутгийн тэтгэмжид 523.4 тэрбум төгрөг;
- бусад зардалд 469.4 тэрбум төгрөг.

Хүснэгт 14 Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл /Бүрэлдэхүүнээр/

Бүрэлдэхүүн	2026 оны төсөв	2027 он			Дүнд эзлэх хувь	Баталсан хязгаараас	Өмнөх оноос
		Хязгаар	ТЕЗ санал	УИХ-д өргөн барьсан			
А	1	2	3	4	5	6=4-2	7=4-1
УТ	22,885.2	25,613.0	33,581.2	31,927.9	60.8	6,314.9	9,042.7
ОНТ	7,330.1	9,593.4	9,836.1	7,584.1	14.4	(2,009.3)	254.0
НДС	6,517.5	7,295.5	9,261.2	9,005.6	17.1	1,710.1	2,488.0
ҮБС	-	-	-	1,000.0	1.9	1,000.0	1,000.0
ЭМДС	2,383.3	2,609.5	2,609.5	3,008.9	5.7	399.4	625.6
Нийт зарлага ба цэвэр зээл	32,980.0	36,493.4		43,586.0	100.0	7,092.6	10,606.0

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

4.1.5 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 60.8 хувь буюу 31,927.9 тэрбум төгрөгийг улсын төсөв, 17.1 хувь буюу 9,005.6 тэрбум төгрөгийг НДС-ийн төсөв, 14.4 хувийг орон нутгийн төсөв, 5.7 хувь буюу 3,008.9 тэрбум төгрөгийг ЭМДС-ийн төсөв, 1.9 хувь буюу 1,000.0 тэрбум төгрөгийг Үндэсний баялгийн сангийн төсөв тус тус эзэлж байна.

4.1.6 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өмнөх оноос 10,606.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд улсын төсөв 9,042.7 тэрбум төгрөг, НДС-ын төсөв 2,488.0 тэрбум төгрөг, Үндэсний баялгийн сангийн төсөв 1,000.0 тэрбум төгрөг, ЭМДС-ийн төсөв 625.6 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 254.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Хуримтлалын санд төвлөрүүлэх 1,000.0 тэрбум төгрөгийг иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор орон сууцжуулах, боловсрол, эрүүл мэндийн чиглэлд иргэдийн нэрийн дансаар зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 15. Монгол Улсын 2027 нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл ангилал, бүрэлдэхүүн /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2026 оны батлагдсан	2027 оны УИХ-д өргөн барьсан	Үүнээс					Өмнөх оноос
			Улсын төсөв	Орон нутаг	НДС	ЭМДС	ҮБС	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,980.0	43,586.0	31,927.9	7,584.1	9,005.6	3,008.9	1,000.0	10,606.0
Урсгал зардал	24,901.0	33,583.2	24,742.3	4,625.6	9,072.8	3,082.9	1,000.0	8,682.2
Цалин, хөлс	6,990.6	9,190.3	8,469.5	709.6	0.1	11.1	-	2,199.7
Нийгмийн даатгалын шимтгэл	-	-	989.4	87.7	-	1.4	-	-
Бараа, үйлчилгээний бусад зардал	2,948.3	3,719.8	2,311.1	1,402.4	2.5	3.8	-	771.5
Хүүгийн зардал	1,299.2	1,572.7	1,572.7					273.5
Татаас	728.2	1,306.8	3,782.8	219.7	-	-	-	578.6
Урсгал шилжүүлэг	12,935.5	17,793.6	7,616.7	2,172.2	9,070.2	3,066.6	1,000.0	4,858.1
Хөрөнгийн зардал	8,568.5	10,333.3	7,374.9	2,958.4	-	-	-	1,764.8
Эргэж төлөгдөх цэвэр зээл	(490.4)	(330.5)	(189.3)	-	(67.2)	(74.0)	-	159.9

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

4.1.7 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 2024 онд 130.7 хувиар огцом өссөнөөс хойш жил бүр өсөх хандлага үргэлжилж, 2027 онд өмнөх оноос 19.5 хувиар нэмэгдүүлсэн нь цалин, хөлсний зардлын суурь тэлж, төсвийн байнгын шинжтэй, хуульчлагдсан зардлын нөлөөлөл өндөр байна.

4.2 Хуульчлагдсан зардлын нөлөөгөөр Монгол Улсын 2027 оны төсвийн зарлага өмнөх оноос 32.2 хувиар нэмэгдсэн байна.

4.2.1 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 2018 оноос эхлэн тогтмол өсөж, эрэлтийн шалтгаантай инфляцыг өдөөж, 2026 оны 8 дугаар сарын байдлаар 13.5 хувьд хүрсэн байна. Төсвийн зарлагын 2027 оны өсөлтөөр дамжуулан зах зээлд 3,000.0 тэрбум төгрөгийг нийлүүлснээр инфляц 1.5 нэгж хувиар нэмэгдэж болзошгүй байна.

4.2.2 Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн тайлангаар төрийн албан хаагчийн тоо, төсвийн байгууллагын тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 16. Төрийн албан хаагчийн тоо хүн амын тооны харьцуулалт /мянга/

Д/д	Он	Хүн амын тоо	Нийт ажиллах хүчний тоо	Төрийн албан хаагч	Нийт хүн амд эзлэх хувь	Нийт ажиллах хүчид эзлэх хувь
1	2020	3,367.3	1,340.0	205.0	6.1	15.3
2	2021	3,419.7	1,317.4	208.9	6.1	15.9
3	2022	3,467.3	1,370.6	225.2	6.5	16.4
4	2023	3,514.5	1,367.3	226.5	6.4	16.6
5	2024	3,554.6	1,441.1	226.9	6.4	15.7
6	2025	3,591.1	1,437.3	213.1	5.9	14.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

4.2.3 Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөлд тусгасан төрийн албан хаагчийн цалинг нэмэгдүүлэх арга хэмжээнд боловсролын салбарт 1,019.5 тэрбум төгрөг, төрийн үйлчилгээний албан хаагчдад 461.1 тэрбум төгрөг, төрийн захиргаа, төрийн тусгай албан хаагчдад 427.0 тэрбум төгрөг, эрүүл мэндийн салбарын албан хаагчдад 372.8 тэрбум төгрөг, бусад салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад 294.0 тэрбум төгрөг, нийт 2,574.4

тэрбум төгрөгийн зардлыг төлөвлөсөн нь хүн амын 6.2 хувь, нийт ажиллах хүчний 15.0 хувьд чиглэсэн байна.

4.2.4 Төрийн албан хаагчдын цалин, иргэдийн суурь тэтгэврийг нэмэгдүүлэхээр төсвийн төсөлд 5,247.2 тэрбум төгрөгийг төлөвлөсөн нь өрхийн орлого, эдийн засгийн дотоод эргэлтийг дэмжих боловч эрэлтээс шалтгаалсан инфляцыг өдөөх эрсдэлтэйг анхаарч, нийлүүлэлтийг тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.

4.2.5 ОУВ18-аас Монгол улс 2023 оны төсвийн тодотголоор төрийн албан хаагчдын цалинг байнгын шинжтэйгээр 30–40 хувиар нэмэгдүүлсэн нь хувийн секторын цалинд нөлөөлж, инфляцын дарамт, урсгал зардлын суурь түвшнийг өсгөснөөр цаашдын төсвийн уян хатан байдлыг хязгаарлаж, төсөв болон эдийн засагт нөлөө үзүүлж байна гэж дүгнэсэн байна.

4.2.6 ОУВС19-ийн тайланд 2026–2027 онд төрийн секторын цалин, тэтгэврийн өсөлт төсөв болон инфляцын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй гэж дүгнэжээ.

4.3 Монгол Улсын 2027 оны улсын төсвийн урсгал зардал нийт зарлага ба цэвэр зээлийн 77.5 хувийг эзэлж, өмнөх оноос 33.2 хувиар нэмэгдсэн байна.

4.3.1 Засгийн газрын 2026 оны 265 дугаар тогтоолоор баталсан улсын төсвийн ерөнхийлөн захирагч нарын нийт зарлага ба цэвэр зээлийн хязгаарыг 25,613.0 тэрбум төгрөгөөр баталсныг 7,968.2 тэрбум төгрөгөөр давуулж, 33,581.2 тэрбум төгрөгөөр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснийг 1,653.3 тэрбум төгрөгөөр бууруулж, 31,927.9 тэрбум төгрөгөөр Улсын Их Хуралд өргөн барьсан нь батлагдсан хязгаараас 6,314.9 тэрбум төгрөгөөр давсан байна.

Хүснэгт 17. Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээл

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2026 оны төсөв	2027 он				Өмнөх оноос
		Хязгаар	ТЕЗ санал	УИХ-д өргөн барьсан	Зөрүү	
А	1	2	3	4	5=4-2	6=4-1
УРСГАЛ ЗАРДАЛ	18,570.0	19,844.7	25,939.4	24,742.3	4,897.6	6,172.3
Бараа үйлчилгээний зардал	9,065.9	10,248.5	12,815.8	11,770.0	1,521.5	2,704.1
Хүү	1,299.2	1,460.0	1,460.0	1,572.7	112.7	273.5
Татаас	2,120.4	2,123.8	4,054.2	3,782.8	1,659.0	1,662.4
Урсгал шилжүүлэг	6,084.4	6,012.3	7,609.4	7,616.7	1,604.4	1,532.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,662.8	5,593.7	7,406.5	7,374.9	1,781.1	2,712.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(347.7)	174.6	235.3	(189.3)	(363.9)	158.4
Нийт зарлага ба цэвэр зээл	22,885.2	25,613.0	33,581.2	31,927.9	6,314.9	9,042.7

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

4.3.2 Нийт зарлага ба цэвэр зээл батлагдсан төсвийн хязгаараас давахад урсгал зардал 4,897.6 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 1,781.1 тэрбум төгрөг, нийт 6,678.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийг 538.5 тэрбум төгрөгөөр бууруулснаас шалтгаалсан байна.

4.3.3 Цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,371.9 тэрбум төгрөгөөр хязгаараас давуулан төлөвлөсөн нь 2026 онд хэрэгжүүлсэн салбарын онцлогт тохирсон цалингийн нэмэгдлийн төсөвт үзүүлэх бүтэн жилийн нөлөөлөл болон салбар хоорондын цалингийн хуримтлагдсан зөрүүг бууруулах зорилгоор 2026 оны 11 дүгээр сараас болон 2027 оны II улирлаас нэмэгдүүлэх цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын 1,112.7 тэрбум төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 259.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

4.3.4 Цалингийн өсөлтөөс үүссэн нэмэлт хэрэгцээг батлагдсан төсвийн хүрээнд нөхөхийн тулд бусад зардлыг бууруулан зохицуулалт хийснээр тухайн жилийн үйл ажиллагааны зардлыг дутуу санхүүжүүлэх, улмаар зайлшгүй шаардлагатай зардлыг дараа жилийн төсөвт шилжүүлэн төлөвлөж, төсөвт тогтмол ачаалал үүсгэсээр байна.

¹⁸ (IMF – Mongolia: 2025 Article IV Consultation)

¹⁹ (IMF – Mongolia: 2026 Article IV Consultation)

4.3.5 Улсын төсвийн 36 ерөнхийлөн захирагчийн төрийн албан хаагчийн орон тоог 258-аар нэмэгдүүлж 69360 байхаар төлөвлөсөн байна.

4.3.6 Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн эх үүсвэр, АМНАТ-ийн төлбөр нэмэгдсэн, орон нутгийн орлого, зарлагын хязгаарт өөрчлөлт орсноор орон нутгийн хөгжлийн санд 146.9 тэрбум төгрөг, орон нутагт олгох санхүүгийн дэмжлэг 264.9 тэрбум төгрөг, нийт 411.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь улсын төсвийн урсгал зарлагын ачааллыг нэмэгдүүлж, төсвийн алдагдалд нөлөөлж байна.

4.3.7 Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд зарим зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор судалгаа хийж, үр дүнг тусгасан. Тухайлбал, төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх 24 хороо, зөвлөл, ажлын албаны үйл ажиллагаанд 17.5 тэрбум төгрөг, гадаад албан томилолтод 74.3 тэрбум төгрөг, хэвлэл мэдээллийн ажил, үйлчилгээнд 22.3 тэрбум төгрөг, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд 61.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

4.3.8 Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд ТЕЗ нарын төлөвлөсөн гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, урсгал засвар, багаж, техник хэрэгсэл, тавилга, эд хогшил худалдан авах зардлыг дээрх судалгааны үр дүнд үндэслэн бууруулах боломжтой байна. Үүнд:

Зардал бууруулах санал:

- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнөөс хэтрүүлэн төлөвлөсөн 7.9 тэрбум төгрөг /БОУАӨС 5.8 тэрбум төгрөг, МУТШСБЭЗХС 2.1 тэрбум төгрөг/;
- Тооцоо, судалгаагаар дэмжигдээгүй, зардлыг төлөвлөсөн 11.4 тэрбум төгрөг /ХЗДХС 6.5 тэрбум төгрөг, ССАЖЗС 2.1 тэрбум төгрөг, ШС 1.3 тэрбум төгрөг, ХББОСС 0.8 тэрбум төгрөг, ЭМС 0.5 тэрбум төгрөг, бусад 3 ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/;
- Цахимаар оролцох боломжтой семинар, уулзалтын зардалд 0.8 тэрбум төгрөг төлөвлөсөн /ССАЖЗС 0.7 тэрбум төгрөг, ХББОСС 0.1 тэрбум төгрөг/;
- Худалдан авалттай холбоотой болон тэвчиж болох зардалд 0.6 тэрбум төгрөг /МУТШСБЭЗХС 0.6 тэрбум төгрөг, ШСХ 0.06 тэрбум төгрөг/;
- Үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй урсгал шинжтэй зардал төлөвлөсөн 0.3 тэрбум төгрөг /ЦХИХХС 0.3 тэрбум төгрөг/;
- Засгийн газраас зөвшөөрснөөс бусад Засгийн газрын гишүүдийн гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авахтай холбоотой зардал төлөвлөсөн ЦАУЗБУК 0.02 тэрбум төгрөг/;

4.4 Төсвийн зардлыг хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй бүрэн уялдуулан төлөвлөөгүй, үр дүнгийн үзүүлэлтүүдийг үндэслэлтэй, хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоогүй байгаа нь хэрэгжилтийн үр дүнг бодитой хэмжих, тайлагнах, үнэлэх боломж буурч, төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт үүсч болзошгүй байна.

4.4.1 Улсын төсвийн 36 ерөнхийлөн захирагчийн 2027 оны төсвийн төсөлд 109 хөтөлбөрийн 264 арга хэмжээний зардалд нийт 31,927.9 тэрбум төгрөгийг төлөвлөсөн нь өмнөх оны батлагдсан төсвөөс 9,042.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. үүнд: 10 хөтөлбөрөөс 252.6 тэрбум төгрөгөөр бууруулж, 1 хөтөлбөрийн 957.3 тэрбум төгрөгийн зардлыг хасаж, 96 хөтөлбөрийн зардлыг 10,252.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 4 хөтөлбөрийн төсвийг өмнөх оны суурь үзүүлэлтийг өөрчлөхгүйгээр тус тус хянасан байна.

4.4.2 Улсын төсвийн 34 ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд 25,053.6 тэрбум төгрөгийн зардал төлөвлөсөн 88 хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан бол төсвийн 5 ерөнхийлөн захирагчийн хүрэх үр дүн шалгуур үзүүлэлт төлөвлөсөн 8 хөтөлбөрт төсөв төлөвлөөгүй байна

4.4.3 Төсвийн 15 ерөнхийлөн захирагчийн 6,874.2 тэрбум төгрөгийн төсөв төлөвлөсөн 34 хөтөлбөрийн хүрэх үр дүнг тооцоогүй байна. Энэ нь төсөв, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн уялдаа хангалтгүй, төсвийн зарцуулалтын үр дүнг хэмжих, хэрэгжилтийг үнэлэх боломжийг хязгаарлаж, үр дүнд суурилсан төсөвлөлтийн зарчим бүрэн хэрэгжээгүй байгааг харуулж байна.

4.4.4 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2027 оны төсвийн төсөлд 43 хөтөлбөрийн 46 арга хэмжээний зардалд 7,584.1 тэрбум төгрөг төлөвлөсөн нь өмнөх оны батлагдсан төсвөөс 254.0 тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд: 2 хөтөлбөрөөс 1,276.2 тэрбум төгрөгөөр бууруулж /Үүнд: Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 1,276.0 тэрбум төгрөг, Засгийн газрын өрийн үйлчилгээ 0.2 тэрбум төгрөг/, 38 хөтөлбөрийн зардлыг

1,530.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 4 хөтөлбөрийн төсвийг өмнөх оны төсвөөр тус тус хянасан байна.

4.4.5 Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төсөлд хөтөлбөр, арга хэмжээг зардлын эдийн засгийн ангиллаар хуваарилан тооцсон төсөв, ТЕЗ-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн хөтөлбөрүүдтэй тохирч байгаа боловч төсвийг арга хэмжээ, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдуулж төлөвлөөгүй байна.

4.4.6 Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны төлөвлөлтүүд нь үр дүнд чиглэсэн байх хуулийн зохицуулалттай боловч төсөвлөлт нь уламжлалт төсөвлөлттэй байгаа нь хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бодитой төлөвлөж, хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаж, үр дүнг үнэлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

БҮЛЭГ 5. ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЛИЙГ ТУСГАЙ ШААРДЛАГА БОЛОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЛИЙГ ХАНГАХААР БОЛОВСРУУЛСАН БОЛОВЧ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ СУЛРАХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.

5.1 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон шинэчилж өргөн барьсан төсвийн хүрээний мэдэгдэлд заасан шалгуурыг хангасан боловч өмнөх оны батлагдсан төсвөөс 1,256.0 тэрбум төгрөгөөр төсвийн алдагдлыг нэмж төсөвлөсөн байна.

5.1.1 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 41,280.0 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 43,586.0 тэрбум төгрөгөөр тооцож, тэнцвэржүүлсэн төсвийн нийт тэнцлийг 2,306.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар 2027 оны төсвийн төслийн саналыг боловсруулжээ.

Хүснэгт 18. Нэгдсэн төсвийн 2027 оны тэнцвэржүүлсэн тэнцэл

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2027 оны төсөл
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	41,280.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,586.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(2,306.0)
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,306.0
Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	144.7
ЗГ-ын үнэт цаас	2,128.5
Урт хугацаат	2,128.5
Дотоод	2,005.2
Шинээр гаргах	2,600.0
Үндсэн төлбөр	(594.8)
Худалдаж авах	-
Гадаад	123.3
Шинээр гаргах	3,694.3
Үндсэн төлбөр	(3,571.0)
ЗГ-ын зээл	32.8
Гадаад	32.8
Төслийн зээл	330.8
Шинээр авах	1,365.4
Үндсэн төлбөр	(1,034.6)
Хөтөлбөрийн зээл	(298.0)
Шинээр авах	488.8
Үндсэн төлбөр	(786.8)

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

5.1.2 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн нийт алдагдал санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,600.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын дотоод үнэт цаас, 3,694.3 тэрбум төгрөгийн гадаад үнэт цаасны арилжаанаас, 1,365.4 тэрбум төгрөгийн Засгийн газрын гадаад төслийн зээл, 488.8 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээлээс тус тус бүрдүүлж, дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 594.8 тэрбум төгрөг, гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 3,571.0 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт 1,821.4 тэрбум төгрөг төлөхөөр тооцоолон төсвийн төсөлд тусгасан байна.

5.2 Монгол Улсын 2027 оны төсвийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах саналыг өргөн мэдүүлсэн байна. Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдахгүй тохиолдолд төсөв төсвийн хүрээний мэдэгдэлд нийцэхгүй байх эрсдэлтэй байна

5.2.1 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг Улсын Их хурлын 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд 1,713.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тусгасан боловч төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд 2,306.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар өөрчлөлт оруулах саналыг хүргүүлсэн байна.

Хүснэгт 19. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2026 он	2027 он			Зөрүү	
	Төсөв	Төсвийн хүрээний мэдэгдэл		УИХ-д өргөн мэдүүлсэн төсвийн төсөл	Өмнөх оноос	Бат.төсвийн хүрээний мэдэгдлээс
		Анх батлагдсан	Тодотгох санал			
А	1	2	3	4	5=4-1	6=2-4
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж дүн	31,930.0	34,780.0	41,280.0	41,280.0	9,350.0	(6,500.0)
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	32,980.0	36,493.4	43,586.0	43,586.0	10,606.0	(7,092.6
Тэнцвэржүүлсэн тэнцэл	(1,050.0)	(1,713.4)	(2,306.0)	(2,306.0)	(1,256.0)	(592.6)

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

БҮЛЭГ 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЛДЭГДЛИЙГ НЭРЛЭСЭН ДҮНГЭЭР 56,628.7 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЭХЭЭР ТООЦСОН НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГАД НИЙЦСЭН БОЛОВЧ ГАДААД ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ ӨНДӨР БАЙГАА НЬ ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ӨР, ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЛИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙНА.

6.1 Төсвийн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 56,628.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ийн 49.6 хувийг эзэлж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт заасан зорилтот түвшнийг хангаж байна.

6.1.1 Улсын Их Хурлын 2025 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт тусгасан 4 зорилтын хүрээнд 2027 онд өрийн удирдлагын дараах бодлогын арга, хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлүүдийг түлхүү ашиглаж, шинээр байгуулах гадаад зээлүүдийг эдийн засгийн үр ашигтай томоохон дэд бүтцийн төслүүдэд чиглүүлэх;
- эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэхэд төсвийн эх үүсвэрийг ашиглахаас гадна хувийн хэвшил, төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалтыг дэмжих;
- байгалийн гамшиг, санхүүгийн хямрал зэрэг гэнэтийн нөхцөл байдал үүсэхэд ашиглах нөхцөлт санхүүжилтийн бүтээгдэхүүн, бодлогод суурилсан зээл зэрэг хэрэгслүүдийг ашиглах;
- гадаад валютын болон хүүгийн эрсдэлийг бууруулах зорилгоор ханшийн болон хүүгийн своп хэлцлийг байгуулах;
- засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг удирдаж, өрийн баталгааны үлдэгдлийг хязгаарлах;
- эрчим хүчний дутагдлыг нөхөх өндөр ач холбогдол бүхий төслүүдийг аймаг, нийслэлийн үнэт цаас гарган санхүүжүүлэх;
- гадаад төлбөрийн тодорхой хэсгийг өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд шийдвэрлэх;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг тогтмол зохион байгуулах бөгөөд санхүүжилтийн хэрэгцээг хангах дотоод эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр байна.

6.1.2 Төсвийн төсөлд Засгийн газрын дотоод өрийг 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 2,012.0 тэрбум төгрөгөөр, гадаад өрийг 4,430.4 тэрбум төгрөгөөр, Өрийн баталгааг 4,587.9 тэрбум төгрөгөөр, нийт 11,030.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, Засгийн газрын өрийг 56,628.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байхаар төсвийн төсөлд тусгасан байна.

Хүснэгт 20. Засгийн газрын өрийн бүтэц, хэрэгсэл

/тэрбум төгрөгөөр/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	2026 ХБГ	2027 Төс	Эзлэх хувь
I. Засгийн газрын дотоод өр		657.3	1,035.5	234.1	1,200.4	1,373.3	3,059.7	5,071.7	9.0
1.1	Засгийн газрын үнэт цаас	657.3	1,035.5	234.1	400.5	688.5	2,110.7	3,897.4	6.9

1.2	Орон нутгийн үнэт цаас				799.9	684.8	949.0	1,174.3	2.1
II. Засгийн газрын гадаад өр		24,693.3	29,641.6	30,274.6	32,021.5	33,868.6	38,504.8	42,935.2	75.8
2.1	Засгийн газрын үнэт цаас	8,175.6	9,359.8	9,371.7	8,655.0	8,964.7	9,366.7	9,596.8	16.9
2.2	Орон нутгийн үнэт цаас				1,724.9	1,828.1	1,886.0	1,955.3	3.5
2.3	Зээл	16,517.7	20,281.8	20,902.9	21,641.6	23,075.9	27,252.0	31,383.1	55.4
III. Засгийн газрын өрийн баталгаа		876.5	811.8	29.5	178.0	165.7	4,033.9	8,621.8	15.2
IV. Концесс ("барих-шилжүүлэх")*		673.9	463.5	230.9	-	-	-	-	-
V. Орон нутгийн зээллэг		17.2	12.3	4.5	-	-	-	-	-
5.1	Дотоод өр	17.2	12.3	4.5	-	-	-	-	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III+IV+V)		26,918.2	31,965.8	30,773.6	33,399.9	35,407.6	45,598.4	56,628.7	
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		21,837.3	27,691.6	26,582.9					
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар**		70.0	70.0	65.0	60.0	60.0	60.0	60.0	
		(ӨҮЦ)	(ӨҮЦ)	(ӨҮЦ)	(НҮ)	(НҮ)	(НҮ)	(НҮ)	
Засгийн газрын өр / ДНБ		61.8	59.4	43.7	41.8	39.4	44.5	49.6	

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл


6.1.3 Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд Засгийн газрын өрийн үлдэгдлийн 75.8 хувийг гадаад өр, 15.2 хувийг Засгийн газрын өрийн баталгаа, 9.0 хувийг дотоод өр тус тус эзэлж байна.

6.1.4 Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2027 онд 11,030.3 тэрбум төгрөгөөр өсгөж төлөвлөсөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Мега төслүүдээс бусад гадаад зээлийн ашиглалт 1,365.4 тэрбум төгрөг, Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа 2,000.0 тэрбум төгрөгөөр, орон нутгийн үнэт цаас 600.0 тэрбум төгрөгөөр;
- Улсын Их Хурлаас 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр баталсан Гадаад зээл ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн хүрээнд "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл", "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл"-ийн хугацаанд ашиглалтад оруулах зорилгоор зээлийн ашиглалтыг 2,471.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх;
- эрчим хүчний салбарт нэн тулгамдсан дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэхэд 1.1 тэрбум ам.доллар хүртэлх Засгийн газрын өрийн баталгаа, Нийслэл Улаанбаатар хотоос 2024 онд Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийг санхүүжүүлэх зорилгоор олон улсын зах зээлд гаргасан үнэт цаасыг дахин санхүүжүүлэлтэд 500.0 сая ам.доллар хүртэлх Засгийн газрын өрийн баталгааг тус тус гаргахаар тооцжээ.

Дүрслэл 1. Тогтвортой байдлын хязгаар

/хувь/



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

6.1.5 Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл ДНБ-ийн 49.6 хувьтай тэнцэж байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиас 10.4 хувиар бага буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон төсвийн тусгай шаардлагыг хангасан байна.

6.1.6 Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон төсвийн тусгай шаардлагыг хангасан боловч сүүлийн 5 жилд 8,489.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгааг анхаарах шаардлагатай.

6.1.7 Засгийн газрын өрийн үндсэн төлбөрт 3,657.3 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 1,572.7 тэрбум төгрөг, нийт өрийн үйлчилгээний төлбөрт 5,230.0 тэрбум төгрөгийг төлөвлөсөн байна.

Хүснэгт 21. Засгийн газрын өрийн үйлчилгээ, нийт төлөвлөгөө /тэрбум төгрөгөөр/

Засгийн газрын өрийн үйлчилгээ	2025 он	2026 он	2027 он
	Гүйц	ХБГ	Төс
В	1	2	3
Үндсэн төлбөр	1,426.9	1,864.4	3,657.3
Дотоод үнэт цаас	-	71.4	220.2
Гадаад үнэт цаас	15.0	146.0	1,615.6
Гадаад зээл	1,411.9	1,647.0	1,821.5
Хүүгийн төлбөр	1,249.9	1,299.2	1,572.7
Гадаад зээл	625.3	613.4	674.0
Гадаад үнэт цаас	35.5	75.0	643.3
Дотоод үнэт цаас	589.1	610.8	255.4
Нийт төлбөр	2,676.8	3,163.6	5,230.0

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

6.1.8 Төсвийн төсөлд Засгийн газрын өрийн үлдэгдэл үндсэн төлбөрийн 6,018.9 тэрбум төгрөгөөр хасагдаж, ашиглалт 14,005.8 тэрбум төгрөгөөр, ханшийн тэгшитгэлийн зөрүү 2,889.8 тэрбум төгрөгөөр, хуримтлагдсан хүү 203.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн эцсийн үлдэгдэл 56,628.7 тэрбум төгрөг байхаар төсвийн төслийг боловсруулсан байна.

Хүснэгт 22. Засгийн газрын өрийн 2027 оны төлөвлөгөө /тэрбум төгрөгөөр/

Д/д	Засгийн газрын өрийн хэрэгсэл	Нэрлэсэн үнээр эцсийн үлдэгдэл 2026	2027 он						
			Ашиглалт	Үндсэн төлбөр*	Ханшийн зөрүү	Хөнгөлөлт /Урамшуулал	Хуримтлагдсан хүүгийн зөрүү	Нэрлэсэн үнээр эцсийн үлдэгдэл	Хүү төлбөр
I. Засгийн газрын дотоод өр		3,059.7	2,600.0	594.8	-	(6.4)	12.9	5,071.7	255.4
1.1	Үнэт цаас	2,110.7	2,000.0	220.2	-	(6.4)	13.3	3,897.4	255.4
1.2	Орон нутгийн үнэт цаас	949.0	600.0	374.6	-		(0.4)	1,174.3	
II. Засгийн газрын гадаад өр		38,504.8	7,005.8	5,392.4	2,820.2	(44.0)	40.8	42,935.2	1,317.3
2.1	Үнэт цаас	9,366.8	1,173.2	1,615.6	706.5	(44.0)	10.0	9,596.8	643.3
2.2	Орон нутгийн үнэт цаас	1,886.0	1,955.3	1,955.3	57.5		11.8	1,955.3	-
2.3	Зээл	27,252.0	3,877.3	1,821.5	2,056.3		19.0	31,383.1	674.0
III	Засгийн газрын өрийн баталгаа	4,033.9	4,400.0	31.7	69.6		150.0	8,621.8	
Нийт		45,598.4	14,005.8	6,018.9	2,889.8	(50.4)	203.7	56,628.7	1,572.7

* Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээнд Засгийн газрын өрийн баталгааны үндсэн төлбөр ороогүй.

6.1.9 Засгийн газрын өрийн үлдэгдэл 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 11,030.3 тэрбум төгрөгөөр буюу 24.2 хувиар өсөхөд дотоодын үнэт цаасны зах зээлийг дэмжих зорилгоор нээлттэй хэлбэрээр арилжаалах 2,000.0 тэрбум төгрөг, шинээр гаргах Засгийн газрын өрийн баталгаа 6,400.0 тэрбум төгрөг голлон нөлөөлсөн байна.

6.1.10 Төсвийн төсөлд Засгийн газрын өрийн үлдэгдэлд ханшийн тэгшитгэлийн зөрүү 2,889.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тооцсон нь гадаад валютаар илэрхийлэгдэх өрийн дүн өндөр байгаагаас шалтгаалан гадаад валютын ханш чангарч, төгрөгийн ханш сулрахад төсөвт ирэх ачаалал нэмэгдэх эрсдэлтэй байна.

6.1.11 Санхүүгийн хөвөгч хүүтэй эх үүсвэрээс олгогдож байгаа ч Засгийн газрын өрийн 79.9 хувийг тогтмол хүүтэй өр төлбөр эзэлж байна. Мөн ашиглагдаагүй зээлийн үлдэгдлийн дийлэнх хэсгийг тогтмол хүүтэй зээл эзэлж байгаа боловч нийт хүүгийн 20.1 хувийг хувьсах хүүтэй зээл, энэ нь гадаад зээлийн 30.8 хувийг эзэлж байна.

6.1.12 Төсвийн төсөлд Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт 3,877.3 тэрбум төгрөгөөр, хуримтлагдсан хүү 19.0 тэрбум төгрөгөөр, ханшийн тэгшитгэлийн зөрүү 2,056.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндсэн төлбөр 1,821.5 тэрбум төгрөгөөр хасагдаж, нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 31,383.1 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөсөн нь Засгийн газрын өрийн багцын 55.4 хувийг эзэлж байна.


Зээлийн ангилал	2026 он ХБГ	2027 он					
		Ашиглалт, буцаалт	Үндсэн төлбөр	Ханшийн зөрүү	Хуримтл агдсан хүүгийн зөрүү	Эцсийн үлдэгдэл нэрлэсэн дүнгээр	Хүүгийн төлбөр
Гадаад зээл	27,252.0	3,877.3	1,821.5	2,056.3	19.0	31,383.1	674.0
Хуваарьт ашиглалт		1,365.4					
Мега төслүүд		2,471.8					
Капиталжуулалт		40.1					
Дүн	27,252.0	3,877.3	1,821.5	2,056.3	19.0	31,383.1	674.0

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

6.1.13 Гадаад зээлээр 2027 онд санхүүжих нийт 96 төслөөс, 28 тусламж, 68 зээлийн төслийн 7 нь хэлэлцээрийн түвшинд, 31 нь шилжих буюу он дамжин хэрэгжих, 28 нь дуусах төслийн зээлүүд байна. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхээр олон улсын хөгжлийн түнш, хандивлагч орон, олон улсын байгууллагатай гэрээ байгуулж, Сангийн ямаар дамжин хэрэгжих нийт 1,365.4 тэрбум төгрөгийн 66 төслийг зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд, 39.0 хувийг Азийн хөгжлийн банкнаас, 21.0 хувийг БНСУ-аас, 20.3 хувийг Дэлхийн банкнаас, 5.7 хувийг ЕСБХБ-аас, 5.5 хувийг БНХАУ-аас, үлдсэн 8.5 хувийг бусад хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас тус тус авахаар төлөвлөжээ.

6.1.14 Засгийн газрын гадаад зээлээр санхүүжих 17 ТЕЗ-аас 68 зээлийн төсөл хөтөлбөрт 5,618.7 тэрбум төгрөгийн санал ирснээс 3,801.8 тэрбум төгрөгөөр, төсвийн хязгаараас 58.8 тэрбум төгрөгөөр бууруулан нийт ашиглалтыг 4,245.3 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүнээс 1,448.8 тэрбум төгрөг буюу 82.0 хувийг хөрөнгийн зардалд, 265.4 тэрбум төгрөг буюу 15.0 хувийг эргэн төлөгдөх цэвэр зээлийн зардалд, 59.1 тэрбум төгрөг буюу 3.0 хувийг урсгал зардалд зарцуулахаар тус тус төсвийн төсөлд тусгасан байна.

Дүрслэл 2. Гадаад зээлийн 2027 оны ашиглалтын төлөвлөгөө



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

6.1.15 Засгийн газрын 2027 оны зээлээр санхүүжих 68 төслийн ашиглалтыг ТЕЗ-аар нь авч үзвэл 229.0 тэрбум төгрөг буюу 16.8 хувийг Нийслэлийн Засаг дарга, 228.6 тэрбум төгрөг буюу 16.7 хувийг ХББОСС, 186.7 тэрбум төгрөг буюу 13.7 хувийг Эрүүл мэндийн сайд, 180.9 тэрбум төгрөг буюу 13.3 хувийг Зам, тээврийн сайд, 150.1 тэрбум төгрөг буюу 11.0 хувийг Эрчим хүчний сайд, үлдэгдэл 389.6 тэрбум төгрөг буюу 28.5 хувийг бусад ТЕЗ нар хэрэгжүүлэхээр байна.

6.1.16 Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн 2,306.0 тэрбум төгрөгийн алдагдлыг Засгийн газрын гадаад хөнгөлөлттэй зээл, дотоод үнэт цаасны эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

6.1.17 Засгийн газрын 2027 оны зээлээр хэрэгжүүлэх төслүүдээс дэд бүтцийн 2 төслийн 2,471.8 тэрбум төгрөгийг Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулиар зээлийн шугамаас гаргасан нь нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

6.1.18 УИХ-аар 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр баталсан Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ болон нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн тухайн жилийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болох бөгөөд нэмэгдсэн дүн нь уг хязгаарт хамаарахгүй”, 3.2-т “Тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталсан гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал нь энэ хуулийн 2.1-д заасан төслийн гадаад зээлийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно” гэж заасантай холбогдуулан зээлийн ашиглалтыг хязгаараас гаргаж, зээлийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.

БҮЛЭГ 7. ТЭРГҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДЛЫН ЭРЭМБЭ, ӨРТГИЙН ТООЦОО СУДАЛГААГ ИХ ӨГӨГДӨЛД СУУРИЛАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ОНОВЧТОЙ, ҮР АШИГТАЙ ТӨЛӨВЛӨХӨД АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

7.1.1 Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14,184.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 815 төсөл, арга хэмжээг 5,773.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 24. Улсын төсвийн 2027 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөл /тэрбум төгрөг/


Ангилал	Шинэ		Санхүүжих дүн	Шилжих			Нийт төсөл, арга хэмжээ		
	Тоо	Төсөвт өртөг		Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	266	4,935.9	2,778.2	469	8,070.0	2,336.8	735	13,006.0	5,115.0
Их засвар	16	127.6	56.2	15	308.1	142.5	31	435.7	198.6
Тоног төхөөрөмж	32	356.7	356.7	8	314.4	59.2	40	671.1	415.9
ТЭЗҮ	2	29.3	23.3	4	24.2	12.2	6	53.5	35.5
Цахим систем	2	4.6	4.6	1	13.1	4.2	3	17.7	8.8
Нийт	318	5,454.1	3,218.9	497	8,729.9	2,554.9	815	14,184.0	5,773.8

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

7.1.2 Тухайн жилийн санхүүжилтэд төлөвлөсөн 5,773.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 55.8 хувийг шинээр эхлүүлэх, 44.2 хувийг өмнөх онуудаас шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

7.1.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтад 2027 онд 5,773.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснийг өмнөх онтой харьцуулахад 1.8 дахин өсөж, 2,493.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дүрслэл 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

7.1.4 “Оюу толгой” ХК-ийн ногдол ашгаас 8 ТЕЗ-ийн төсвийн багцын 2,356.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 52 төсөл, арга хэмжээг 2,000.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь дээрх өсөлтөд голлон нөлөөлжээ.

Хүснэгт 25. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн төлөвлөсөн эх үүсвэр /тэрбум төгрөг/

Санхүүжилтийн эх үүсвэр	Код	Нийт төсөл, арга хэмжээ					
		Тоо	Эзлэх хувь	Төсөвт өртөг	Эзлэх хувь	Санхүүжих дүн	Эзлэх хувь
Улсын төсвийн хөрөнгө	УТ	763	93.6%	11,827.9	83.4%	3,773.8	65.4%
Оюу Толгой ХК-ийн ногдол ашиг	ОТ	52	6.4%	2,356.0	16.6%	2,000.0	34.6%
Нийт		815	100%	14,184.0	100%	5,773.8	100%

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

7.1.5 “Оюу толгой” ХХК-аас ногдол ашиг авах асуудлаар Монгол Улсын Засгийн газраас ажлын хэсэг байгуулагдаж, гэрээ хэлцлийг эхлүүлсэн боловч ногдол ашиг хуваарилах талаар

ТУЗ-ын албан ёсны шийдвэр одоогоор гараагүй байгааг анхаарах нь зүйтэй байна. Тус орлогоос 2027 онд шинээр эхлүүлж, тухайн онд санхүүжүүлэн дуусгахаар 8 салбарт хэрэгжих 52 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь эрсдэлтэй байна. Үүнд:

ЭХС-ын төсвийн багцад 18 төсөл, арга хэмжээнд 789.7 тэрбум төгрөг, тухайлбал:

- Дулааны VI-р цахилгаан станцын 300 МВт-ын хөрөнгө оруулалт /Улаанбаатар/ төсөл, арга хэмжээнд 400.0 тэрбум;
- 10 аймгийн дулааны станц төсөл, арга хэмжээнд 152.6 тэрбум;
- орон нутгийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэл /Говь-Алтай, Ховд, Увс, Завхан/ төсөл, арга хэмжээнд 40.0 тэрбум;

ЗТС-ын төсвийн багцад 7 төсөл, арга хэмжээнд 305.0 тэрбум төгрөг, тухайлбал:

- Жаргалант-Шинэ-Идэр-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 151.5 км /Хойд бүс/ төсөл, арга хэмжээнд 61.0 тэрбум;
- Нөмрөг - Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замын үргэлжлэл /Баруун бүс/ төсөл, арга хэмжээнд 41.2 тэрбум;
- Ховд-Улиастай чиглэлийн хатуу хучилттай авто замын эхлэл /Баруун бүс/ төсөл, арга хэмжээнд 42.6 тэрбум;

Боловсролын сайдын төсвийн багцад 17 төсөл, арга хэмжээнд 572.7 тэрбум төгрөг, тухайлбал:

- Олон улсын хөтөлбөртэй төрөлжсөн 9 ахлах сургуулийн дотуур байр барих төсөл, арга хэмжээнд 154.2 тэрбум;
- бүсийн төрөлжсөн 6 ахлах сургуулийн дотуур байр барих төсөл, арга хэмжээнд 102.8 тэрбум;
- эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж, ашиглалтын зардал болон байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулан, ухаалаг шийдлийг үе шаттай нэвтрүүлэх “Ногоон, ухаалаг сургууль” төсөл, арга хэмжээнд 240.7 тэрбум;
- боловсролын салбарын сургалтын орчин, тоног төхөөрөмжийн хүртээмжийг сайжруулах төсөл, арга хэмжээнд 75.0 тэрбум төгрөг тус тус төлөвлөж, 2027 онд бүрэн санхүүжүүлж дуусгахаар тусгажээ.

7.1.6 Ногдол ашиг хуваарилахтай холбоотой ТУЗ-ын албан ёсны шийдвэр гарч эрх зүйн хувьд тодорхой болсны үндсэн дээр төсвийн төсөлд тусгасан дээрх 52 төсөл, арга хэмжээ хэрэгжих боломж бүрдэхээр байна.

7.2 Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөр тухайн жилд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 2027 оны төсвийн төсөлд бүрэн тусгасан байна.

7.2.1 Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталсан. Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 2027 онд улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр 36 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 2026 онд хэрэгжиж дуусах 3 төсөл, арга хэмжээг хасаж, 33 төсөл, арга хэмжээг 2027 оны төсөвт тусгахаар байна.

7.2.2 Дээрх 33 төсөл, арга хэмжээнээс 31 төсөл, арга хэмжээг буюу 93.9 хувийг улсын төсвийн 2027 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөлд тусган дунд хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт төлөвлөсөн ажлуудыг бүрэн тусгажээ.

7.2.3 ТЕЗ-аас төсвийн төсөлд санал ирүүлээгүйгээс “Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах төсөл”, Хүүхдийн ордон байгуулах, засвар шинэчлэл хийх ажлыг Хүүхдийн сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр шийдвэрлэснээр “Хүүхдийн номын ордон, хүүхэлдэйн театр” төсөл, арга хэмжээг тус тус улсын төсвийн 2027 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөлд тусгаагүй байна.

7.2.4 Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөс 2027 онд санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээг Улсын төсвийн 2027 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад бүрэн тусгаж төлөвлөсөн байна.

7.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2027 оноос эхлэн хэрэгжүүлэх 318 төсөл, арга хэмжээний 18.2 хувь нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй нь богино хугацааны бодлого зорилт, түүний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

7.3.1 Улсын Их Хурлын 2026 оны 29 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөг баталж, тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 316 зорилт, арга хэмжээнээс 221 зорилт, арга хэмжээг улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлж, хэрэгжүүлэхээр тусгажээ.

7.3.2 ЭЗХЯ-наас Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд нийцсэн гэж дүгнэсэн ч аудитаар дараах зөрчил илэрч байна.

7.3.3 Төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2027 оноос эхлэн шинээр хэрэгжүүлэх 318 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 4,460.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 260 төсөл, арга хэмжээ буюу 81.8 хувь нь хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, хөтөлбөрийн үр дүнтэй уялдсан, 993.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 58 төсөл, арга хэмжээ буюу 18.2 хувь нь хөтөлбөрийн үр дүнтэй уялдаагүй байна.

Хүснэгт 26. УТХО-ын төсөл, арга хэмжээнүүд болон УХЖТ-ний уялдаа /тэрбум төгрөг/

УТХО	УХЖТ-тэй уялдсан эсэх	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	
		Дүн	Тоо	Хувь
Шинээр хэрэгжүүлэх 318 ТАХ	УХЖТ-тэй уялдсан	4,460.3	260	81.8
	УХЖТ-тэй уялдаагүй	993.8	58	18.2
	Нийт	5,454.1	318	100

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл, Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө

7.3.4 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийт 33 салбарын үр дүнг төлөвлөснөөс 22 салбарын үр дүнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд чиглэжээ.

Хүснэгт 27. УХЖТ-ний хөтөлбөрийн үр дүнтэй уялдаагүй 58 төсөл, арга хэмжээ

№	ТЕЗ	Уялдаагүй ТАХ-ний тоо	Хөтөлбөрийн үр дүн
1	ЗТС	19	5.7.1.1. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.
		9	5.7.1.2. Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн шинэчилж, бүсийн төв, нийслэл хоорондын зорчих хугацааг бууруулна.
		6	5.4.1.1. Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. 9.3.2.1. Чөлөөт бүс дэх аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлнэ. 8.1.2.5. Зүүн бүс: Хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
2	ХЗДХС	5	4.2.4.2. Цагдаагийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлнэ.
3	УЕП	4	7.2.3.1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны үед хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээнэ.
4	БХС	3	7.7.1.2. Төрлийн цэргийг бэхжүүлж, энхийг дэмжих ажиллагааны үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлнэ.
5	ГБХНХС	2	4.2.3.1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулна.
6	ХХААХҮС	1	5.1.2.1. Малын гаралтай түүхий эдийг дотооддоо бүрэн боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
		1	5.1.2.2. Хөнгөн үйлдвэрийн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлнэ.
7	Бусад ТЕЗ	8	-
Нийт		58	

Эх сурвалж: Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө, Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэл

7.3.5 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хөтөлбөрийн үр дүнгийн 5.7.1.1²¹, 5.7.1.2²² дахь заалтад олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлэх, бүсийн төв, нийслэл хоорондын зорчих хугацааг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

7.3.6 ЗТС-ын төсвийн багцад тэргүүлэх эрэмбэ, үр ашгийг тооцохгүйгээр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний дээрх зорилттой уялдаагүй авто замын ажлыг буюу аймаг, дүүрэг, сумын төвийн доторх болон сум хоорондын авто замын 566.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тухайлбал:

- Толбо сумаас Дэлүүн сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 1 дүгээр үе шат /Баян-Өлгий/ ТАХ, төсөвт өртөг 41.8 тэрбум төгрөг;
- Мөрөн сумын босоо хэвтээ тэнхлэгийн авто замын өргөтгөл, шинэчлэлт /Хөвсгөл, Мөрөн сум/ ТАХ, төсөвт өртөг 28.3 тэрбум төгрөг;
- сумын хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 5.1 км /Булган, Булган сум, 2, 4, 5 дугаар баг/ ТАХ, төсөвт өртөг 9.2 тэрбум төгрөг;

²¹ 5.7.1.1 "Олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ"

²² 5.7.1.2 "Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн шинэчилж, бүсийн төв, нийслэл хоорондын зорчих хугацааг бууруулна"

- сумын төвийн хатуу хучилттай авто замын дуусгал, 1.2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/ TAX, төсөвт өртөг 3.9 тэрбум төгрөг;
- сумын төвийн хатуу хучилттай авто зам /Завхан, Тосонцэнгэл сум/ TAX, төсөвт өртөг 10.0 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

7.3.7 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн зөрчил өмнөх онтой (12.1 хувь) харьцуулахад 6.1 нэгжээр өссөн байна. Энэ нь богино хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлд нийцээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашиг багатай зардалд хуваарилж зарцуулахад хүргэж байна.

7.3.8 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан шалгуур үзүүлэлтүүдэд бүрэн нийцүүлж, төсөл, арга хэмжээний заалттай нарийвчлан уялдуулж, төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчмыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

7.4 Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг эрэмбэлж үнэлсэн ч аргачлалын дагуу бус, бодитой, оновчтой байдал хангалтгүй байгаа нь үр ашиг, хэрэгцээ шаардлага багатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрсдэлийг дагуулж байна

7.4.1 Төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2027 оноос эхлэн шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн ангилалд 4,935.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 266 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

7.4.2 Шинээр төлөвлөсөн 266 барилга байгууламжаас 242 төсөл, арга хэмжээнд хийсэн зардал-үр дүнгийн шинжилгээний мэдээллийг цахим системд оруулсан бол 15 төсөл, арга хэмжээнд дүн шинжилгээ хийгдээгүй, 9 төсөл, арга хэмжээг холбогдох журмын дагуу төлөвлөсөн байна.

7.4.3 Зардал, үр ашиг, үр дүнгийн шинжилгээг хийсэн төсөл, арга хэмжээ 94.1 хувьтай боловч шинжилгээг бүрэн, бодитой, үндэслэлтэй тооцоолоогүй, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө тодорхойгүй, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай талаарх үнэлэлт дүгнэлт хийгээгүй, үр ашигтай байдал хэмжигдэхүйц бус, шинжилгээ хэлбэрийн төдий байгаа нь төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг оновчтой сонгох, төлөвлөх боломжийг хязгаарлаж байна. Тухайлбал:

- ЗТС-ын төсвийн багцад 8.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн их тойруу хатуу хучилттай авто зам, 27.9 км /Архангай, Эрдэнэбулган сум/, 7.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй А0302 дугаартай авто замаас Нарийнтээл сумын Баянтээг баг чиглэлийн 22 км хатуу хучилттай авто зам, 1 дүгээр үе шат /Өвөрхангай, Нарийнтээл сум/, 8.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Увс/;
- ҮХЦ-ийн даргын төсвийн багцад 3.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Үндсэн хуулийн цэцийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар/;
- ХЭҮК даргын төсвийн багцад 7.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/;
- ХЗДХС-ын төсвийн багцад 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цагдаагийн газрын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо/ төсөл, арга хэмжээг төлөвлөжээ.

7.4.4 Төсвийн ерөнхийлөн захирагч нар шинээр хэрэгжүүлэх нийт 1011 TAX-г төсвийн төсөлд тусгуулахаар Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ээр төлөвлөн санал хүргүүлснээс барилга байгууламжийн ангилалд хамаарах нийт 617 TAX-г Сангийн яам үнэлж эрэмбэлэн 266 TAX-г төсвийн төсөлд тусган УИХ-д өргөн мэдүүлжээ.

7.4.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх эрэмбэлэх аргачлалд “эрчим хүчний хэмнэлттэй эсвэл ногоон хөрөнгө оруулалт эсэх” шалгуур үзүүлэлтийг, мөн цахим системийн төлөвлөлт хэсэгт “ногоон болон уур амьсгалын төслийг таних” асуумжийг нэвтрүүлэн хөгжүүлж байгаа нь байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.4.6 Шинээр эхлүүлэх барилга байгууламж, их засварын ажлууд төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй байх асуудал жил бүр давтагдаж байгаа нь эрсдэлтэй тул зураг төсөв боловсруулах, магадлал хийх тогтолцоог сайжруулах шаардлагатай.

7.4.7 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2027 оноос шинээр хэрэгжүүлэхээр тусгасан барилга байгууламж, их засварын ангиллын 5,063.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 282


төсөл, арга хэмжээний зураг төсвийг төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг хянахад дараах байдалтай байна. Үүнд:

- Нийт төсөл, арга хэмжээний 27.3 хувь буюу 1,814.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 76 төсөл, арга хэмжээ нь баталгаажсан зураг төсөвгүй; /Зураг төсвийг магадлалаар баталгаажуулах шатанд байгаа талаар ТЕЗ нараас мэдэгдэл ирүүлсэн/
- Хуульд заасан хүчинтэй хугацаа хэтэрсэн буюу зураг төсвийг шинэчлэх шаардлагатай төсөл арга хэмжээ 8.2 хувь буюу 334.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээ; /Зураг төсвийг магадлалаар баталгаажуулах шатанд байгаа талаар ТЕЗ нараас мэдэгдэл ирүүлсэн/
- Нийт төсөл, арга хэмжээний 3.9 хувь буюу 93.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээг нэг маягийн зураг төсвөөр тус тус төлөвлөсөн байна.

7.4.8 Энэ нь төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29^{2.2} дахь заалтыг хангаагүй байгаа бөгөөд төсвийг хэлэлцүүлэх үед шаардлага хангасан байхаар тооцож байгаа талаар ТЕЗ нараас мэдээлэл ирүүлсэн.

7.4.9 Магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх төсөвлөлтийн шаардлагын хувьд магадлал албажих шатандаа байгаа төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж төлөвлөх асуудал жил бүр давтагдаж байгаа нь өмнөх онд (6.3 хувь) харьцуулахад 33.1 нэгжээр өссөн байгаа бөгөөд ТЕЗ-аар авч үзвэл дийлэнх нь Боловсролын сайд, ЗТС, ЭМС, ССАЖЗС-ын төсвийн багцад хамаарч байна. Иймд цаашид зураг төсөв боловсруулах, магадлал хийх тогтолцоо, үйл ажиллагааг төсвийн төслийн төлөвлөлттэй уялдуулах шинэчлэх шаардлагатай байна.

Дүрслэл 4. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ, ТЕЗ-аар



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

7.4.10 ЗТС, ССАЖЗС, АТГ, ЭМС, Шадар сайдын багцын 6 төсөл, арга хэмжээний магадлалаар баталгаажсан төсөвт өртөг, их засварын ажлын төсөвт өртөг 83.3 тэрбум төгрөг, ТЕЗ-ийн ирүүлсэн саналаар буюу 6.2 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд илүү дүнгээр тусгасан байна. Үүнд:

- ССАЖЗС-ын төсвийн багцад Соёлын төвийн барилга /Увс, Сагил сум/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1.0 тэрбум төгрөгөөр, Соёлын төвийн барилга /Увс, Бөхмөрөн сум/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 0.8 тэрбум төгрөгөөр;
- АТГ-ын төсвийн багцад Авлигатай тэмцэх газрын мэдүүлгийн өрөөний засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 0.07 тэрбум төгрөгөөр;
- Шадар сайдын төсвийн багцад Монгол Улсын гамшгаас хамгаалах нэгдсэн удирдлагын штабын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 3.5 тэрбум төгрөгөөр;
- ЗТС-ын төсвийн багцад Улиастай сумаас Богдын гол чиглэлийн 7.7 км хатуу хучилттай зам, 60 у/м төмөр бетон гүүр /Завхан, Улиастай сум/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 0.6 тэрбум төгрөгөөр;
- Боловсролын сайдын төсвийн багцад Үйлдвэрлэл, урлалын политехник коллежийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 0.2 тэрбум төгрөгөөр тус тус илүү тооцсон байна.

7.4.11 Дээр дурдсан 6 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн дүнг магадлалаар баталгаажсан төсөвт өртгийн дүн болон холбогдох баримтад үндэслэн бууруулж залруулах шаардлагатай.

7.4.12 Төрийн аудитын байгууллагаас 2025 онд гүйцэтгэсэн “Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт дүгнэлт гаргах” аудитын хүрээнд зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэхээр ТЕЗ нараас санал ирүүлсэн магадлалаар баталгаажуулсан зураг төсөв нь

²³ 29^{1.2.2}.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

алдаатай байх тул төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах боломжгүй талаар захиалагч, зохиогч, гүйцэтгэгч талуудад албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэн.

7.4.13 Өртөг нэмэгдүүлэхээр магадлалаар баталгаажуулж санал ирүүлсэн зураг төсөв нь алдаатайгаас төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах боломжгүй талаар мэдэгдэл хүргүүлсэн төсөл, арга хэмжээнээс дараах 7 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2027 оны төсвийн төсөлд 11.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Хүснэгт 28. Зураг төсөв алдаатай 7 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл /тэрбум төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг		
		Сүүлд батлагдсан	2027 оны төсвийн төсөл	Зөрүү буюу нэмэгдүүлсэн
1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дархан-Уул, Дархан сум, 14 дүгээр баг/	5.4	6.1	0.6
2	Музейн барилгын дуусгал /Дорнод, Хэрлэн сум/	4.5	7.8	3.4
3	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилгын дуусгал /Говьсүмбэр/	12.4	15.4	2.9
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сүхбаатар, Уулбаян сум/	3.5	5.0	1.6
5	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Сэлэнгэ, Цагааннуур сум, 3 дугаар баг/	4.1	4.9	0.8
6	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, Малчин баг/	3.8	4.9	1.1
7	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Баянцогт сум/	2.6	3.6	1.0
	Нийт	36.3	47.7	11.4

Эх сурвалж: 2025 онд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

7.4.14 Барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг магадлалаар баталгаажсан зураг, төсвийн дүнд үндэслэхгүйгээр төсвийн төсөлд тусгаж байгаа нь өртгийг илүү, дутуу төлөвлөхөд хүргэж, цаашлаад өртөг нэмэгдэх эсэх маргааныг дагуулж төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрахад нөлөөлж болзошгүйг анхаарах шаардлагатай байна.

7.4.15 Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дугаар тушаалаар “Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм”, 2017 оны 114 дүгээр тушаалаар “Барилга байгууламжийн үнийн индекс тооцох дүрэм”, 2022 оны 206 дугаар тушаалаар “Барилгын төсөвт өртгийн өөрчлөлтийг томсгосон хэлбэрээр тооцох аргачлал” -ыг тус тус баталсан боловч эдгээр аргачлалыг хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төсөвт өртгийг тодорхойлох, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлах үе шатанд хэрхэн хэрэглэх эсэх талаар зохицуулалт тодорхойгүй байна.

7.4.16 Үүний улмаас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа барилга байгууламжийн төсвийн анхан шатны баримт бичиг болох нэг бүрчилсэн төсөв, үе шатны ажлын тоо хэмжээнд үндэслэн тендер зарлаж байгаа нь ажлын тоо хэмжээ орхигдуулах, дутуу тооцох зэрэг алдаа гарч улмаар төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг үүсгэж байна.


7.4.17 Иймд барилга байгууламжийн төсөвт өртгийг томсгосон норм, үнэлгээнд үндэслэн тооцож төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд ашиглах, улмаар дараагийн шатанд нэг бүрчилсэн төсвөөр нарийвчлан баталгаажуулах тогтолцоог судалж шийдвэрлэх шаардлагатай байна.

7.5 Тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний тэргүүлэх хэрэгцээ шаардлага, өртгийг суурь өгөгдөл, судалгаанд тулгуурлан төлөвлөхгүй байгаа нь төсвийн зарцуулалтын үр ашигт сөргөөр нөлөөлж байна

7.5.1 Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд 19 ТЕЗ-ийн төсвийн багцад 356.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авах 32 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

7.5.2 Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд шинээр хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний 356.7 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн 63.6 хувийг улсын төсвөөс, 36.4 хувийг “Оюу толгой” ХК-ийн ногдол ашгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Дүрслэл 5. Улсын төсвийн тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний санхүүжилт /эх үүсвэрийн төрлөөр/



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл

7.5.3 Шинээр худалдан авах тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний өртгийн 90.4 хувь нь 8 ТЕЗ-ийн төсвийн багцад ногдож байгаа бөгөөд үүнээс боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль зүйн салбарт 195.2 тэрбум төгрөг буюу 54.7 хувийг төлөвлөсөн бол ХХААХҮС-ын болон ЗГХЭГ, Шадар сайд, Сангийн сайдын төсвийн багцад 127.0 тэрбум буюу 35.7 хувийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Дүрслэл 6. Шинээр хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээ /тэрбум төгрөгөөр/



* Бусад 11 ТЕЗ: Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий аудитор, АТГД, УЕП, УДШЕШ, ЭХС, ГХС, УИХД, ГБХНХС, ССАЖЗС, ЭЗХС

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл

7.5.4 ХХААХҮС-ын төсвийн багцад 36.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж” /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээг төлөвлөсөн боловч худалдан авах тоног төхөөрөмжийн нэр, худалдан авах тоо хэмжээ, нэгжийн болон нийт үнэ зэрэг багцын задаргаа мэдээлэл тодорхойгүй, нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, зориулалт нь тодорхой бус байдлаар төлөвлөгдсөн байна.

7.5.5 ЭМС-ын төсвийн багцад 50.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/

төсөл, арга хэмжээний хүрээнд 2,124 ширхэг тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагуудаас ирүүлсэн саналд тулгуурлан төлөвлөжээ.

7.5.6 Эрүүл мэндийн салбарын хувьд салбарын байгууллага бүрээр лавлагаа шатлал, үзүүлэх үйлчилгээтэй уялдсан техник, тоног төхөөрөмжийн норм хэмжээ, стандарт хангалтгүй, тодорхой бус, шаардлагатай болон ашиглагдаж буй хөрөнгийг харьцуулах, насжилт, ашиглалтын байдлаар эрэмбэлж хэрэгцээг тодорхойлохгүйгээр санал авч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь оновчтой бус, үндэслэл муутай байна.

7.5.7 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар жил бүр тодорхой хөрөнгө оруулалтыг тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээнд төлөвлөж зарцуулж байгаа боловч салбар бүрийн түвшинд техник, тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, ашиглалтын хугацааг тогтоосон норм, стандарт хангалтгүй, тодорхой бус байна.

7.5.8 Салбарын түвшинд болон харьяа байгууллага бүрээр нэгтгэсэн өгөгдөл, суурь мэдээлэл дутмаг, иж бүрэн бус, судалгаа, мэдээллүүд нь бодит бус, зөрүүтэй, нэр төрөл, ангилал нь байгууллага, салбар бүрд харилцан адилгүй, жигд бус байна. Энэ нь тоног төхөөрөмжийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох, эрэмбэлэхэд шаардлагатай суурь өгөгдөл хангалтгүй, иж бүрэн бус, нэгдсэн ангилал, код хэрэглэх, тогтмол шинэчлэх сайжруулах, мэдээлэл солилцох, систем хооронд интеграци хийх тогтолцоо бүрдээгүй байгааг харуулж байна.

7.5.9 Сангийн яамнаас төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд их өгөгдлийн дэд систем бүрдүүлэх, төсвийн төлөвлөлтөд ашиглах чиглэлд санаачилга гарган гадаадын зээл тусламжийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийг нэгтгэж үндсэн системийн бүрэлдэхүүн хэсэг болгон хөгжүүлж байна. Мөн Зам тээврийн хөгжлийн төвийн www.eroad.rtdc.gov.mn, Боловсролын салбарын www.esis.edu.mn, ҮСХ-ны www.1212.mn, ТӨБЗГ-ын www.umch.gov.mn системүүдтэй холбогдож мэдээлэл солилцох ажлууд хийгдэж байна.

7.5.10 Салбарын суурь өгөгдөл бүрдүүлэх чиглэлд ТЕЗ нараас Боловсролын яам харьцангуй ахиц дэвшил гаргаж, улсын хэмжээнд аймаг нийслэл, сум дүүрэг, байршил, сургууль бүрээр хүчин чадал, ашиглалт, багш, суралцагчийн тоо, хамран сургах тойргийн суралцагчийн тоо, анги дүүргэлт, ээлжийн коэффициент, барилга байгууламжийн ашиглалтад орсон хугацаа, насжилт, их засвар хийсэн он зэрэг мэдээлэл бүхий өгөгдөл сан бүрдүүлэн ашиглаж байна.

7.5.11 Боловсролын сайдын төсвийн багцад 75.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Боловсролын салбарын сургалтын орчин, тоног төхөөрөмжийн хүртээмжийг сайжруулах” /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хэрэгжиж дуусах хугацааг 2027 оноор тусгасан 58 сургууль, 41 цэцэрлэгийн барилгыг хуульд заасан хугацаанд бүрэн ашиглалтад орохоор тооцож анги танхим, багш ажилчдын ширээ, сандал, тавилга, техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнийг худалдан авахаар төлөвлөжээ.

7.5.12 Үүнээс 11 сургууль, 9 цэцэрлэг нь 2026 оноос эхлэн шинээр хэрэгжиж 2027 онд дуусахаар хуульд төлөвлөгдсөн, тухайн 20 барилгын ажлын гүйцэтгэл нь 30 хүртэл хувьтай хэрэгжиж байгаа нь төлөвлөсөн хугацаандаа буюу 2027 онд бүрэн ашиглалтад орж, үйл ажиллагаагаа эхлүүлэн тавилга, тоног төхөөрөмжийг ашиглах эсэх нь эргэлзээтэй байна.

7.5.13 Тоног төхөөрөмжийн нэгжийн үнийн судалгаагүй, зах зээлийн үнийг олон эх үүсвэрээс судалж харьцуулахгүйгээр 4 ТЕЗ нийт 1091 нэр төрлийн тоног төхөөрөмжийн өртгийг 59.0 тэрбум төгрөгөөр төлөвлөж саналд хүргүүлсэн нь төсвийн төсөлд тусгагджээ.

7.5.14 Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1²⁴, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7²⁵ дахь заалтад тус тус нийцэхгүй байна.

7.5.15 Цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төлөвлөхөд шаардлагатай салбар бүрийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тоо хэмжээний норм, жишиг стандартыг тогтоох, түүнд тулгуурлан шаардлагатай тоо хэмжээ болон төрийн өмчид бүртгэлтэй, ашиглаж буй тоног төхөөрөмжийн тоо, ашиглалтын хугацаа,

²⁴ 6.4.1. “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”

²⁵ 4.2.7. “Аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх”

хүчин чадал болон ашиглалтын байдал зэрэг суурь өгөгдөл бүрдүүлэх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход тэдгээрийг үнэлж эрэмбэлж ашиглах шаардлагатай байна.

7.6 ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төсөл, арга хэмжээний өртгийг бодитой, төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, хяналт хангалтгүй байгаа нь эрсдэл дагуулж байгааг анхаарах шаардлагатай байна.

7.6.1 Төсвийн төсөлд ТЭЗҮ боловсруулах 53.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 35.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээг төлөвлөжээ. Үүнээс ЭЗХС, ХББОСС-ын төсвийн багцад тус бүр нэг буюу нийт 29.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 23.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй ТЭЗҮ боловсруулах 2 шинэ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

7.6.2 ТЭЗҮ боловсруулах дээрх 2 шинэ төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 22 багцын задаргаа ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч өртгийг хэрхэн тооцсон талаарх төсвийн задаргаа, тоон мэдээлэл, үндэслэл, тооцоолол тодорхойгүй байна.

7.6.3 ЭЗХС-ын төсвийн багцад 19.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр төлөвлөсөн “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ” /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний хүрээнд 20 багцад задарсан ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

7.6.4 Дээрх ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 20 ажлаас ЭЗХС-аас төсвийн төсөлд анх /2026.07.25-нд/ санал хүргүүлсэн 10 багц ажил нь дунд хугацааны бодлогын баримт бичиг буюу Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт суурилсан байна. Харин төсвийн төслийг нэгтгэн боловсруулах явцад нэмж санал хүргүүлсэн 4 багц, Засгийн газрын шийдвэрээр нэмсэн 6 багц ажлын хэрэгцээ, шаардлага, өртгийн тооцоолол, үндэслэл тодорхойгүй байгаа нь төсөвт өртгийг хэрэгцээ шаардлагад тулгуурлан бодитой, тооцож төлөвлөх суурь зарчимд нийцээгүй байна.

7.6.5 Аудитын явцад төсвийн төсөлд анх санал хүргүүлсэн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 13.8 тэрбум төгрөгийн 10 багц ажлын хүрээнд хийх ажилбарууд, тэдгээрт хуваарилсан өртгийн ерөнхий мэдээллийг ирүүлсэн ч өртгийн задаргаа харилцан адилгүй, баримталсан норм дүрмийн заалт, ажлын тоо хэмжээ, жишиг үнэ, тариф, үндэслэл нь тодорхойгүй, хийх зарим ажилбарын ерөнхий үнэлгээг дараах байдлаар харилцан адилгүй өртөгтэйгөөр төлөвлөсөн байна.

Дүрслэл 7. ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд хийх ажлын өртгийг харилцан адилгүй төлөвлөсөн байдал



Эх сурвалж: ЭЗХЯ-аас ирүүлсэн төсөвт өртгийн ерөнхий тооцоолол

7.6.6 ЭЗХЯ нь ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төсөл, арга хэмжээний санал, өртгийн тооцоог хариуцсан яам, агентлаг, байгууллага, нэгжээс шаардан авч, хянахгүйгээр төсвийн төсөлд тусгаж байгаа бөгөөд төсөвт өртгийг оновчтой тодорхойлж төлөвлөх, хянах тогтолцоо хангалтгүй, түүнийг бүрдүүлэх, сайжруулах чиглэлд төрийн аудитын байгууллагаас дүгнэлт

зөвлөмж удаа дараа хүргүүлж байгаа ч Засгийн газар, хариуцсан яамд ахиц дэвшил гарахгүй байна.

7.7 Тухайн жилийн санхүүжилтийг дутуу төлөвлөж байгаа нь хэрэгжилт удаашрах, дараагийн жилүүдийн хөрөнгө оруулалтын орон зайг хязгаарлах эрсдэлийг дагуулж байна

7.7.1 УТХО-аар 2027 оноос эхлэн шинээр хэрэгжих 5,454.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 318 төсөл, арга хэмжээг төлөвлөжээ. Үүнд:

- 2,205.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 111 төсөл, арга хэмжээг тухайн жилд хэрэгжүүлж дуусгахаар;
- 3,248.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 207 төсөл, арга хэмжээг хоёроос гурван төсвийн жил дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

7.7.2 Нэг жилд хэрэгжих 111 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 2027 онд бүрэн төлөвлөсөн бол хоёроос гурван жил дамжин хэрэгжих 207 төсөл, арга хэмжээний 94.7 хувь буюу 196 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилж төлөвлөөгүй байна.


7.7.3 Дээрх 196 төсөл, арга хэмжээний 3,248.8 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс 2027 онд 1,202.5 тэрбум төгрөгийн санхүүжилт ногдохоор байхад төсвийн төсөлд 224.1 тэрбум төгрөгөөр дутуу буюу 18.6 хувиар бууруулж 978.4 тэрбум төгрөг төлөвлөжээ.

7.7.4 Шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дутуу төлөвлөж тусгадаг зөрчил жил бүр давтагдаж байгаагаас Төсвийн тухай хуулийн 29.3.5²⁶ дахь заалт хэрэгжихгүй байна.

7.7.5 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилан төлөвлөж, 3 жилд багтаан санхүүжүүлж дуусгах зарчмыг хэрэгжүүлэхгүй байгаа нь төсөл, арга хэмжээ анх төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй удаашрахад нөлөөлөхөөс гадна дараагийн жилүүдэд шинэ төсөл, арга хэмжээг эхлүүлэх хөрөнгө оруулалтын орон зайг хязгаарлаж байгааг анхаарах шаардлагатай байна.

7.7.6 Улсын төсвийн урсгал зардал 2023 онтой харьцуулахад 2026 онд 66.9 хувиар өссөн ба нийт зарлагад эзлэх хувь нь жил бүр өсөж, төсвийн зарлагын бүтцэд урсгал зардлын давамгайлал улам нэмэгдэж байна.

Дүрслэл 8. 2023-2026 оны Улсын төсвийн зарлагын бүтцийн өөрчлөлт /нийт зардалд эзлэх хувиар/



Эх сурвалж: Монгол Улсын 2023-2026 оны төсвийн тухай хуулиуд

7.7.7 Төсвийн зарлагын бүтцэд урсгал зарлагын эзлэх хувь жил бүр өсөж хөрөнгийн зардлын хувийн жин буурч байгаа нь хөрөнгө оруулалтаар дамжуулан хөгжлийн бодлогын томоохон зорилтуудыг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

7.7.8 Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын суурь харилцааг Төсвийн тухай хуулиар зохицуулж байгаа ч төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, бүртгэх, тайлагнах зэрэг

²⁶ 29.3.5. "Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах";

асуудлуудыг бусад хууль тогтоомжоор болон Засгийн газар, Сангийн сайдын баталсан журам, аргачлалаар зохицуулж байгаа нь нэгдсэн зохицуулалт, уялдаа холбоо хангалтгүй, хяналт хариуцлагын тогтолцоо сул байхад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

7.7.9 Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн байгууллагууд болон бусад оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, төлөвлөлт, зарцуулалт, тайлагналт ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

НАЙМ. ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

8.1.1 Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

8.1.2 Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг баталгаажуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой юм.

8.1.3 Монгол Улсын 2022-2026 онд өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд хийсэн аудитаар хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, улсын хөгжлийн төлөвлөгөө, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн орлоготой холбоотой өгсөн зөвлөмжүүд дийлэнх хувийг эзэлж байна.

8.1.4 Монгол Улсын 2022-2026 оны төсвийн төсөлд хийсэн аудитаар нийт 75 зөвлөмжийг Засгийн газар, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн байна.

Дүрслэл 9. Аудитаар хамгийн олон давтагдсан зөвлөмж



Эх сурвалж: Үндэсний аудитын газар

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 41,280.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.8 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 43,586.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.8 хувь, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2,306.0 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэж байна.
2. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангаж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.
3. Олон улсын геополитик, эдийн засгийн төлөв байдал харилцан адилгүй, гадаад зах зээл дэх газрын тос, уул уурхайн түүхий эдийн эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалан худалдааны түнш орнуудын бодлогын сорилтуудтай тулгарч болзошгүй байна.
4. Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлтэй хамт дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зорилт хангагдахгүй байх, ач холбогдол буурах, төсвийн тогтвортой байх зарчим алдагдахад хүргэж байна.
5. Төсвийн төсөлд Төсвийн тухай хуульд заасан шаардлагуудыг зарчмын хувьд хангаж байгаа боловч төсвийн зарлагын өсөлт, урсгал зардал ДНБ-ий 30 хувийн дээд хязгаарт ойртсон, орлогын өсөлтөд уул уурхай болон төрийн өмчит компаниудын ногдол ашиг өндөр нөлөөтэй байгаа нь төсвийн тогтвортой байдал, зохистой удирдлагад эрсдэл учруулж болзошгүй байна.
6. Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгжийн төлөх татварыг бууруулах, төрийн өмчит хуулийн этгээдийн ногдол ашгийг дайчлах зэрэг зоримог бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь сайн талтай боловч түүхий эдийн мөчлөг, гадаад зах зээлийн сорилтоос шалтгаалан төсвийн орлого тасрах, эх үүсвэрийн дутагдлыг дараа жилийн татвараас урьдчилан төвлөрүүлэх эрсдэл үүсгэж болзошгүйг анхаарч, холбогдох тооцоо судалгааг нарийвчлан үзэж, шийдвэрлэх шаардлагатай байна.
7. Төрийн албан хаагчдын цалин, суурь тэтгэврийг нэмэгдүүлэхээр төсвийн төсөлд 2,104.2 тэрбум төгрөгийг төлөвлөсөн нь өрхийн орлого, эдийн засгийн дотоод эргэлтийг дэмжих боловч эрэлтээс шалтгаалсан инфляцыг өдөөх эрсдэлтэйг анхаарч, улсын стратегийн нөөцийг тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.
8. Хуульчлагдсан зардлын нөлөөгөөр Монгол Улсын 2027 оны төсвийн зарлага өмнөх оноос 32.2 хувиар нэмэгдэж, төсвийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн орон зайг хязгаарлах, төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна.
9. Цалингийн өсөлтөөс үүссэн нэмэлт хэрэгцээг батлагдсан төсвийн хүрээнд нөхөхийн тулд бусад зардлыг бууруулах зохицуулалт хийснээр байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, зардлыг дутуу санхүүжүүлэх, шаардлагатай зардлыг дараа жилийн төсөвт шилжүүлэн төлөвлөж, төсөвт тогтмол ачаалал үүсгэхээр байна.
10. Зарим төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2027 оны төсвийн төслийг үндэслэл, тооцоо судалгаагаар бүрэн нотлоогүй, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлттэй уялдаагүй нийт 21.1 тэрбум төгрөгийн зардлыг бууруулах боломжтой байна.
11. Монгол Улс үр дүнд суурилсан төсвийн бодлоготой ч Төсвийн тухай хуулийн хөтөлбөр, арга хэмжээний төсвийг төсөв захирагчийн тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдуулан төлөвлөдөггүй, өмнөх жилийн төсвийг суурь болгон өсөн нэмэгдэх байдлаар дараа жилийн төсвийг бэлтгэдэг уламжлалт төсөвлөлттэй хэвээр байна.
12. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулиар гадаад төслийн зээлийн ашиглалт нэмэгдсэнээр гадаад өрийн хэмжээ, зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдэх эрсдэлтэй байна.

13. Сэлбэ дэд төвийн төсөлд Засгийн газрын өрийн баталгаа гаргаж, богино хугацаатай, гадаад үнэт цаасны эх үүсвэрээр санхүүжүүлсэн нь төсвийн дарамтыг нэмэгдүүлж, дахин санхүүжилт хийх нөхцлийг бүрдүүлсэн байна.
14. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2027 оноос эхлэн хэрэгжүүлэх 318 төсөл, арга хэмжээний 58 төсөл, арга хэмжээ нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хөтөлбөрийн үр дүнтэй уялдаагүйгээс хөрөнгө оруулалтын зарцуулалт бодлогын зорилтот үр дүнг хангахад бүрэн чиглээгүй байна.
15. Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний 94.1 хувьд зардал үр ашиг, үр дүнгийн шинжилгээг хийсэн ч шинжилгээг бүрэн, бодитой, үндэслэлтэй тооцоолоогүй, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө тодорхойгүй, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай талаарх үнэлэлт дүгнэлт хийгээгүй, үр ашигтай байдал хэмжигдэхүйц бус, шинжилгээ хэлбэрийн төдий байгаа нь төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг оновчтой сонгох, төлөвлөх боломжийг хязгаарлаж байна.
16. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй барилга байгууламж, их засварын ажлуудыг төсөвт тусгах асуудал жил бүр давтагдаж, магадлалаар баталгаажсан зураг, төсвийн дүнд үндэслэхгүйгээр төсөвт өртгийг төлөвлөж байгаа нь өртгийг илүү, дутуу төлөвлөхөд хүргэж, цаашлаад өртөг нэмэгдэх эсэх маргааныг дагуулан хэрэгжилт удаашрахад нөлөөлж болзошгүйг анхаарах шаардлагатай байна.
17. Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм, барилгын төсөвт өртгийн өөрчлөлтийг томсгосон хэлбэрээр тооцох аргачлалыг хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төсөвт өртгийг тодорхойлох, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үе шатанд хэрэглэх боломж нөхцөлийг судалж, тогтолцооны түвшинд шийдвэрлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.
18. Магадлалаар баталгаажсан төсөвт өртгөөс илүү дүнгээр төсөвлөгдсөн 6.2 тэрбум төгрөгөөр 6 барилга байгууламж, зураг төсөв нь алдаатайгаас төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах боломжгүй талаар мэдэгдэл хүргүүлснийг залруулахгүйгээр төсөвт өртгийг 11.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн 7 төсөл, арга хэмжээг тус тус 2027 оны төсвийн төсөлд төлөвлөснийг хянаж шийдвэрлэх шаардлагатай.
19. Тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний тэргүүлэх хэрэгцээ шаардлага, бодит өртгийг норм, үнэлгээгээр тоо хэмжээ, бүртгэлтэй хөрөнгийн насжилт, ашиглалтын байдал зэрэг суурь өгөгдөл, зах зээлийн үнийн судалгаанд тулгуурлаж төлөвлөхгүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна.
20. ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээний өртгийг бодитой, үндэслэлтэй тооцож төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, хяналт хангалтгүй байгаа нь эрсдэл дагуулж байгааг анхаарч, цаашид зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай.
21. Төсвийн тухай хуулийн шаардлагыг бүрэн баримтлахгүйгээр тухайн жилийн санхүүжилтийг дутуу төлөвлөж байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, дараагийн жилүүдийн хөрөнгө оруулалтын орон зайг хумих эрсдэлийг дагуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа дунд хугацааны төсвийн төлөвлөлттэй нийцүүлж, төсвийн тогтвортой байдлын зарчмыг алдагдуулахгүй байх талаар Засгийн газарт чиглэл өгөх
2. Төсвийн төслийг дагалдуулан хууль, тогтоолын төслүүдийг өргөн мэдүүлэхдээ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан нийтлэг болон тусгай шаардлагуудыг хангасан байх талаар тус тус чиглэл өгөх;
3. Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн байгууллагууд болон бусад оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, төлөвлөлт, зарцуулалт, тайлагналын ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх;
4. Барилга байгууламжийн төсөвт өртгийг томсгосон норм, үнэлгээнд үндэслэн тооцож, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд ашиглах, дараагийн шатанд нэг бүрчилсэн төсвөөр нарийвчлан баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэх чиглэлийг холбогдох байгууллагад өгөх;
5. ТЭЗҮ боловсруулах төсөвт өртгийг оновчтой тодорхойлж төлөвлөх, хянах тогтолцоо хангалтгүй, түүнийг бүрдүүлэх, сайжруулах чиглэлд төрийн аудитын байгууллагаас удаа дараа дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь эрсдэл дагуулж байгааг анхааралдаа авч, шаардлагатай зохицуулалтыг бий болгож, хариуцлагажуулах;

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Төсвийн тогтвортой байдлын зарчмыг баримтлан, төсвийн тусгай шаардлагыг хангаж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлж байх;
2. Гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ буурч төсвийн орлого тасрах эрсдэлтэй нөхцөлд төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авч ажиллах;
3. Төсвийн орлогыг үндэслэлтэй тооцох, дараа оны татварын орлогоос урьдчилан төвлөрүүлэхгүй байх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, үр ашиггүй хөнгөлөлт, чөлөөлөлтийг бууруулах зэрэг санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримтлах;
4. Урсгал зардлын өсөлтийг бодит хэрэгцээ, бодлогын зорилт, хүрэх үр дүнтэй уялдуулан тооцож, байнгын шинжтэй зардлын өсөлтийг хязгаарлах, төсвийн хөрөнгө оруулалт болон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн орон зайг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
5. Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан үр дүнд хүрэхийн тулд Төсвийн тухай хуулийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсөв захирагчийн тухайн оны төсөвтэй уялдуулан төлөвлөх.